

БӨХӨНГИЙН МЭДЭЭ

Бөхөнгийн хамгаалал, экологийн талаар мэдээлэл солилцох 6 хэл дээр гарч буй хэвлэл



Зургийг: И.Шилеенок

Шинэхэн төрсөн бөхөнгийн ихэр янзага – биднийг хамгаалаач!

Редакцийн зүгээс

Уралын популяцид хамаарах (Баруун Казахстан) ойролцоогоор 12000 бөхөн 2010 оны 5-р сард үхсэн байна. *Saiga news*-ийн энэ дугаарт энэхүү эмгэнэлт явдлын олон тал, түүний шалтгаан, нөхцөл байдлыг хэлэлцсэн гурван өгүүллээс бид түүвэрлэн орууллаа. Энэ явдал нь бөхөнгийн Уралын популяцид төдийгүй зүйлийн хувьд хүнд цохилт болж, бөхөнгийн популяцийн өсөлтийг хязгаарлагч хүчин зүйлд өвчин эмгэг байж болохыг бидэнд санууллаа. Бөхөн хамгаалах CMS-ийн харилцан ойлголцлын тухай тунхаглагч талуудын зөвлөлгөөн 9-р сард болох ба дараагийн дунд хугацааны ажлын хөтөлбөрийг зөвшилцөхийн өмнөхөн энэ сануулга бидэнд ирлээ. Бөхөнгийн аль популяцид нэлээд хэдэн жилийн туршид халдварт өвчний дэгдэлт байгаагүй учраас бөхөн хамгааллын ажлын хөтөлбөрийг 2006 онд хэлэлцэх үед өвчин эмгэгийг зүйлийн хувьд бодитой аюул гэж хэлэлцээгүй билээ.

Казахстаны засгийн газар энэ эмгэнэлт явдлыг зогсоох талаар маш түргэн, үр дүнтэй, зохион байгуулалттай арга хэмжээ авлаа. Казахстандаа бөхөнгийн үхэл хэвлэл мэдээллийнхэний анхаарлыг ихээхэн татсан нь энэ зүйл үндэсний ач холбогдолтойг харуулж байна. Үхлийн энэ тохиолдол мөн олон улсын байгууллагуудын анхаарлыг татаж энэ сэдвээр сэтгүүл, сонингуудад нийтлэл гарсан байв. Эцэст нь байгаль хамгаалах олон улсын байгууллагууд түргэн хугацаанд Казахстаны удирдлагад дэмжлэг үзүүлсэнв Үүнд: ямар тусламж хэрэгтэйг хэлэлцэхийн тулд CMS утсаар хурал зохион байгуулж, FFI- олон улсын байгууллага болон Бөхөн хамгаалах эвслийнхэн Мухамед Бин Зуиедийн сан, Save Our Species People's Trust for Endangered Species сангуудын хандивын тусламжийг татах замаар олон улсын санхүүжилтыг олж чадсан.

үргэлжлэл нь 2-р хуудсанд.

Энэ дугаарыг доорх байгууллагууд
санхүүжүүлэв:

Агуулга

Редакцийн зүгээс	1
Форум Казахстан дахь бөхөнгийн их хэмжээний үхэл– ойролцоогоор 12000 бодгаль үхжээ.....	2
Мэдээ	5
Өгүүлэгүүд <i>Энхтүвшин Шийлэгдэмба, Баярбаатар</i> <i>Бүүвэйбаатар, Аманда Файн, Бадамжав</i> <i>Лхагвасүрэн, Ким Муррей, Жоел Бергер</i> Гэрийн амьтдын өвчинд монгол бөхөнгийн (<i>Saiga</i> <i>tatarica mongolica</i>) өртөмтгий байдал.....	10
<i>Николай Франов, Вячеслав Гагарин</i> “Астраханское” улсын туршилтын ангийн аж ахуй дахь бөхөнүржүүлэг.....	11
<i>Алтай Жатканбаев</i> Зүүн хойд Прибалхаш (Казахстан) бол зүйлийн дэлхэц нутаг дахь бөхөнгийн (<i>Saiga tatarica tatarica</i>) хадгалагдаж үлдсэн бас нэг амьдрах орчин.....	13
<i>Денис болон Артур Нуриджанов</i> “Возрождение” хойг дахь бөхөнгийн популяцийн судалгаа	13
<i>Анатолий Хлуднев</i> Бөхөн хамгаалал бол нийтийн үйл хэрэг	14
<i>Гуйхан Цзян</i> Эмнэлэгт бөхөнгийн эврийг орлуулж гэрийн одос үхрийн эврийг ашиглах нь	15
<i>Хау К., Обгенова О., Милнер-Гулланд Э.Дж</i> ОХУ-д мэдээлэл сурталчилгааны компаниг ажлын үр дүнг үнэлэх нь	16
<i>Айзада Нурумбетова</i> Хайраа шингээсэн бүхэн үр шимээ өгдөг	17
Төслүүдийн тойм	18
Шинэ бүтээлүүд	20

1-р хуудасны үргэлжлэл.

Уралын популяцийг сэргээхэд хамгийн яаралтай бөгөөд чухал зорилтуудыг шийдвэрлэх болон халдварт өвчний судалгааг явуулах, бөхөн хамгаалахад нутгийн иргэдийг татах зэрэг үйл ажиллагаанд санхүүжилтыг шууд ашиглахын тулд олон улсын төрийн бус байгууллагууд Казахстаны биологийн олон янз байдлыг хамгаалах нийгэмлэг болон байгаль хамгааллын төрийн байгууллагуудтай нягт хамтрах болно. Зөвхөн уралын популяцид хүнд цаг үе тохиолдсон төдийгүй Устюртэд популяцийн тогтвортой байдалд хууль бус агнуур үргэлжлэн заналхийлж, Баруун Хойд Прикаспийд ч мөн зуд болж хууль бус агнуур ч нөлөөлсөөр байна. Монголын болон Бетпақдалийн популяциудын хувьд нөхцөл байдалд илүү таатай байна. Харилцан ойлголцлын тухай тунхаглалын 2006 оны анхны зөвлөлгөөнөөс хойш олон зүйл дээр амжилтанд хүрсэн ч бид бөхөн хамгаалах дунд хугацааны хөтөлбөрт тавигдсан зорилгондоо хүрэхийг, энэ зүйлийн тоо толгойн буурах хандлагыг таслан зогсоохыг хүсвэл байгаль хамгааллын үйл ажиллагаагаа үргэлжлүүлж, хүчтэй болгох ёстой. CMS- ийн 9-р сарын зөвлөлгөөн дээр маш олон хүмүүс оролцоно гэж би итгэж байна.

Проф. Э.Дж.Милнер- Гулланд
Бөхөн хамгаалах эвслийн дарга
e.j.milner-gulland@imperial.ac.uk

Форум

Казахстан дахь бөхөнгийн их хэмжээний үхэл– ойролцоогоор 12000 бодгаль хорогджээ.

Бөхөнгийн их хэмжээний хорогдол 2010 оны 5–р сарын 18–наас 21–ны хооронд Баруун Казахстан мужийн баруун хойд хэсэгт Борсы тосгоноос хойд зүгт төллөхөөр бөөгнөрсөн үед болжээ. 11920 бөхөн үхсэнээс 7625 шаргачин, 4250 янзага (дөнгөж төрсөн) болон 45 ооно байв: энэ нь Уралын нийт популяцийн ойролцоогоор гуравны нэг (2010 оны 4-р сард ойролцоогоор 39 мянган бодгаль тоологджээ) байв.

Мал эмнэлэг, амьтан судлал, анагаах ухаан, байгаль хамгаалах байгууллагуудын мэрэгжилтэн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй комиссын урьдчилсан дүгнэлтээр бөхөнгийн их хэмжээний хорогдлын шалтгаан нь хүнд өвлийн дараа ид төллөх үеэр болон магадгүй техникийн гаралтай хлорт органик нэгдлүүдийн хортой нөлөөний улмаас хээлттэй организмуудын байгалийн дархлаа буурсаны учир цусан суулга (*Pasteurella multocida*) дэгдсэн гэжээ.

Зарим хорогдсон бөхөн болон гэрийн малаас (зургаан тугал) эмгэгийн дээж авч Баруун Казахстан мужийн мал эмнэлгийн лаборатори, Уралын тархварын эсрэг станцуудаас хийгдсэн лабораторийн шинжилгээний дүн дээр шинжилгээний хариуг гаргажээ. Түүнчлэн Казахстаны мал эмнэлгийн үндэсний төвөөс үхсэн бөхөнгөөс эдийн дээж, хөрс, ургамлаас дээжлэн судлахад амьтдын ходоод, гэдэс, элгэнд хлорын ионы агуулга ихэссэн (3.3 дахин), харин хөрс, ургамалд 5.3 - 8.0 дахин ихэссэн нь илэрсэн.

Өмнө нь Казахстанд цусан суулгаар бөхөн их хэмжээгээр үхсэн тохиолдлууд 1981, 1984, 1988 онуудад ажиглагдаж байсан. Өмнө нь Тургай мужийн нутагт 1981 оны 5-р сард ойролцоогоор 100 мянган бөхөн, 1988 оны 5-р сард ойролцоогоор 270 мянга, Волго-Уралын хөндийд 1984 оны 2-3 саруудад 100 мянга гаруй бөхөн хорогдсон байна. Дээрх бүх тохиолдолд хорогдсон бөхөнгийн (2010 онд ч мөн адил) ам болон хамрын хөндийгөөс хөөрсөрсөн цусархаг зүйлс



зургальц ИА Вестни-Россия

Казахийн тархвар судлаачид бөхөнгийн үхлийн шалтгааныг судлаж байна.

ялгарсан, бөгснийх нь сүвнээс шингэхэн баас цусны хольцтой ялгарсан болохыг тэмдэглэв.

Сэгнүүдийг нээж үзэхэд хэвлийн хөндий цусаар дүүрсэн, уушиг нь хавчийсан, элэг дэлүү нь нэлээд томорч цусжсан байсан. Өвчтэй бодгалиуд нэлээд эцсэн, гуйвсан алхаатай, амьсгал хүнд, шүлс нь урссан, булчин чичрэн татсан болох нь ажиглагдсан. Өвчлөл маш хурц хэлбэрээр явагдаж, өвчтэй бодгалиуд 3-6 өдрийн дотор үхсэн. Цусан суулгын иймэрхүү дэгдэлтийн шалтгаан бүрэн тодорхой бус юм. Зарим эрүүл бодгалиуд өвчин үүсгэгчийг тээгч болох бөгөөд тодорхой нөхцлүүдэд тэдгээрийн вирусийн чанар идэвхжиж, их хэмжээний өвчлөл үхэл хорогдлыг өдөөж болох юм. Их хэмжээний үхэл болоогүй байхад заримдаа өвчтэй бодгалиуд тааралдах тохиолдлууд мэдэгдэж байгаа нь халдвар дэгдэлтийн хоорондох хугацаанд халдвар хадгалагдаж үлдэхэд ганц нэгэн өвчтэй бодгалиуд эсвэл зарим бодгалиудад далд хэлбэрээр өвчлөл явагдахад үүрэг гүйцэтгэдгийг гэрчилж байна. 1988 болон 2010 оны 5-р саруудад цусан суулга дэгдэхэд нөлөөлсөн боломжтой шалтгаануудын нэг бол эдгээр жилүүдэд ер бусын их цастай өвлийн дараа бөхөнгүүд эцэж сульдсан байсан. 1988 оны өвөл бөхөнгүүд тэжээлийн хомсдлоос болж үхэцгээсэн.

Бөхөнгийн их хэмжээний үхэл хорогдлыг урьдчилан сэргийлэх үүднээс комиссоос тэмдэглэсэн гол арга хэмжээнүүдэд: амьтад болон тэдгээрийн амьдрах орчны мониторинг, бөхөнгийн өвчлөл, тэдгээрээс сэргийлэх арга хэмжээнүүдийг судлах, бэлчээр нутгийн халдварын судалгаа, гэрийн малыг вакцинжуулах болон цусан суулгын голомтуудыг халдваргүй болгох, цусан суулгын халдвараас ард иргэдийг хамгаалах ажлыг зохион байгуулах зэрэг байв.

Доктор Ю.А. Грачев, док, проф. А.Б.Бекенов
Амьтан судлалын хүрээлэн, Казахстан
teriologi@mail.ru



зургальц Республика KZ

Цусан суулгаар үхсэн бөхөнгүүд, 2010 оны 5-р сар

Цусан суулгаар бөхөн хорогдох боломжит шалтгаанууд

Казахстанд өмнө нь ч цусан суулгаар бөхөн өвчлөх болон хорогдох тохиолдлууд гарч байсан. Цусан суулгын халдвар Монголд ч зэрлэг мэрэгчдийн дунд цайвар үлийч (*Lasiopodomys brandtii*), монгол тарваганд (*Marmota sibirica*) илэрч байсан. Гэхдээ хамгийн олон хорогдол цагаан зээрэнд (*Procapra gutturosa*) гарч байсан. 1974 онд ойролцоогоор 140 мянган цагаан зээр үхэж байсан бол дараа нь 1980, 1983, 1985 онуудад энэ зүйлийн их хэмжээний хорогдол давтагдаж байсан. Түүнчлэн цусан суулгын халдвар 5 жилийн туршид одоо «Астраханское» улсын агнуурын аж ахуйн үржүүлгийн төвд буй бөхөнгүүдэд халдсаар буйг тэмдэглэх хэрэгтэй (Н.А.Франова болон В.В.Гагарина нарын өгүүллийг доороос харна уу). Энгийн нөхцөлд цусан суулгын өвчин үүсгэгчид амьтдын амьсгалын замын дээд хэсгийн салслаг бүрхүүлд байршиж ямар нэгэн

хортой нөлөө үзүүлэлгүй оршино. Ихэнхдээ цусан суулгын өвчин үүсгэгчид өвчлөлийн анхдагч шалтгаан болохгүй боловч ямар нэгэн тааламжгүй нөхцөлд өртсөн амьтад халдсаар байдаг. Өвчлөл маш хурц хэлбэрээр явагдаж өвчин дэгдсэн мөчөөс ямагт 10-30 цагийн дараа бодгалиудын үхлээр төгсдөг. Ийм дэгдэлт үүсэхэд ямар зүйл түлхэц болдог вэ: зуд, өөр гаралтай халдварууд, тэжээлийн хомсдол, хэт халах эсвэл хөрөх? Иймэрхүү дэгдэлтийн мөн чанарыг танин мэдэхэд тухайн цаг үедээ Монголд хийгдэж байсан судалгаа (Ротшильд нар 1988) сонирхол татаж байна. Цагаан зээрийн үхэл хорогдол тэжээлийн ургамал дахь бичил элементүүдийн хэвийн бус

¹ Ротшильд Е.В., Евдокимова А.К., Амгалан Л. Ургамал дахь бичигл элементүүдийн хэвийн бус агууламж цагаан зээрийн хорогдлын шалтгаан болох нь. МОИП бюлл. Отд.Биол. 1988, Т. 93, В.2, х. 35-42.

агуулгатай холбоотой байжээ. Амьтдын хүнд хэлбэрийн өвчлөлүүд ургамал дахь зэс, молибдений агуулга алдагдсан, тугалга, цайрын концентраци нэмэгдсэн, кобальтийн дутагдалтай холбоотой болохыг харуулсан, үр дүнд нь эндемик атакси (хөдөлгөөний зохицуулалтын хомсдол) бий болж гэдэсний хямрал, бусад дотоод эрхтний үйл ажиллагаа хэвийн бус болдог. Энэ үед эцсэн, сульдсан бус харин тарга гэвээрэг сайтай том амьтад үхсэн. Цагаан зээр хавар зуны улиралд үхэх үед бэлчээрийн ургамлуудад зэсийн маш хүчтэй дутагдал үүсэж кобальт хангалтгүй болсон байсан; зуны төгсгөлөөр тугалга болон цайр бие организмд нэлээд хэмжээгээр нэмэгдэж ургамлын өөрчлөлт гарсан, эцэст нь бэлчээрийн хязгаарлагдмал талбайд амьтад молибдений их хэмжээний дозыг авах болсон гэжээ. Бүхэлдээ, зэрлэг амьтад биогеохимийн хэвийн бус хортой нөлөөнөөс хамгаалагдсан гэж үзэх үндэс байхгүй бөгөөд энэ хүчин зүйл зэрлэг амьтны

аймагт учирах янз бүрийн гамшигт төлөвийн боломжит хүчин зүйлсийн нэг гэж тооцох нь зүйтэйг Ротшильд бусдын хамт бичсэн байдаг. Үүнтэй холбоотой судалгаанууд одоо байгаа популяцийн хамгаалал, ховор зүйлүүдийг сэргээн нутагшуулах үндэслэл, хүний нөлөөллийг прогнолох, мал аж ахуй, хүний эрүүл мэндэд учирах хохирлоос сэргийлэхэд шууд чиглэсэн байдаг. Амьтны бие организмд зарим бичил элементүүд илүүдлээр шингэх хортой нөлөөллийг хүхрийн хүчлийн зэсийн (зэсийн байван) илүүдэл дозыг амьтны тэжээлд нэмэх замаар зохиомолоор сулруулж болно. Хонины бэлчээр дээр энэ аргыг практикт амжилттай хэрэглэсэнийг (онгоцноос зэсийн нунтагласан зэсийн байвангийн кристаллуудыг цацах маягаар) Ротшильдийн өгүүллэгт тодорхойлон бичсэн байсан. Баруун Казахстан дахь бөхөнгийн үхлийн шалтгааныг тайлбарлахад бөхөн үхсэн нутгуудаас тэжээлийн бүрэлдэхүүний биогеохимийн судалгааны дээжүүдийг цуглуулбал мэдээж сайн юм.

Доктор А.А. Лушекина,
МАБ/ ЮНЕСКО-ийн Оросын хороо
saigak@hotmail.com



Цагаан зээрийн сүрэг.

Зэрлэг туруутан амьтдын цусан суулга өвчнөөр өвчлөх тохиолдлууд

Mannheimia болон *Bibersteinia* төрлийн бактериудаар үүсгэгдэг дэлхий дээр өргөн тархсан өвчин юм. Нэг зүйлийн дотор ч заримдаа илүү хүнд өвчлөлүүдийг үүсгэдэг маш олон хэлбэрүүд байдаг. Цусан суулгын бүрдэлтэй бактериуд эрүүл эзэн биеийнхээ амьсгалын замын эрхтэнүүдэд ч оршиж байж болно. Тоос болон шимэгч хорхойгоор эсвэл хортой бодисоор үүсэн өвдөлтүүд, стресс эсвэл тэжээлийн дутагдлаас үүдэлтэй амьсгалын замын халдварууд, дархлаа буурах зэрэг нь бактериудыг уушиг, цусны систем руу нэвтрэх таатай нөхцлүүдийг үүсгэж байдаг. Өвчин нь уушгины хатгаа эсвэл бүр үхэлд ч хүргэхээр хүндрэлтэй байж болно. Үхлийн дараах онцлог шинжүүд гэвэл хэвлийн хөндий хөөх, ам, хамрын эргэн тойронд хөөсөрсөн байдал юм. Бактери цусанд халдварласан газруудад цус алдах, гүйлгэх зэргээр хүндэрч үхэлд маш хурдан хүргэдэг. Гэрийн хонинд цусан суулга өвчин амьсгалын замын өвчлөлийн хүндэрсэн шатнуудад ихэнхдээ хурга эсвэл хөгшин бодгалиудад үүсдэг, мөн хоргодол ихтэй томоохон дэгдэлт үүсгэж болно. Бактериуд бие организмын гадна талд удаан хугацаагаар амьдарч чадахгүй боловч бодгалиудын хооронд шууд замаар дамждаг. Цусан суулга дэгдэхэд хүргэдэг олон хүчин зүйлсийн хослол нь гэрийн хонин дээр ч бүрэн тодорхой бус байдаг. Дэгдэлт голчлон янз бүрийн газраас ирсэн амьтад холилдооны дараа жишээлэхэд зах дээр явагддаг. Холилдооны дүнд шинэ эмгэг хэлбэр цусанд нэвтрэх эсвэл амьтдын өндөр нягтшил болон стрессийн улмаас явагддаг байж болно. Дархлааны системийг дарангуйлагч бусад өвчнүүдийн адилаар амьсгалын замын вирусун халдварууд мөн цусан суулгын дахин дэгдэлтийг өдөөж болно. Зэрлэг амьтад цусан суулгын бактерийн зарим хэлбэрүүдэд гэрийн малаас ч илүүтэй эмзэг байж болох юм. Жишээлэхэд бүдүүн эвэрт аргаль хонь *Ovis canadensis* цусан суулгад маш эмзэг учраас энэ өвчний дэгдэлт байнга гардаг Хойд Америкийн зарим нутгуудад популяци 90% хувь хүртэл буурсан. Зарим дэгдэлтүүд гэрийн хониноос эмгэг хэлбэрүүд халдварласанаас үүсдэг байхад зарим нь амьсгалын замын вирус болон стрессээс үүссэн өвчинтэй холбоотойгоор зэрлэг

хонины бие организмд байх эмгэгийн бус бактерийн үндсэн дээр хөгжих боломжтой гэж үздэг. Энэ зүйл хонин дээр *Ovis canadensis* цусан суулгын дэгдэлтийн дараагийн жилүүдэд залуу бодгалиудын тоо буурахад хүргэх учир цаашдаа популяцийн амьдрах чадварыг бууруулдаг. Өвчин дэгдсэний дараа түр хугацаанд цусан суулгын бактериуд нь бусад зүйл зэрлэг хивэгчдээс тусгаарлагдсан байдаг. Гэвч олон хүчин зүйлийн харилцан нөлөөл болон эрүүл организмын биед ч бактериуд байдаг учраас үхлийн ийм шалтгаануудад цусан суулгын үүргийг тодорхойлоход хүнд, эсвэл бүр боломжгүй ч байдаг. Мэдээжийн хэрэг, цусан суулгын шинжүүдийг бусад боломжит дагалдах хүчин зүйлсийн үнэлгээ дагалдах ёстой. Үүнд мөн парагриппийн вирус болон амьсгал-синцитиаль вирус эсвэл бусад стресс үүсгэгчдийг илрүүлэх шинжилгээг оруулж болно. Бөхөнгийн хувьд хаврын улиралд стресс үүсгэгчид бол хүнд өвлийн дараах тэжээлийн хомсдол, төллөх үеийн эм бөхөнгийн дархлаа буурах явдал юм. Ерөнхийдөө, янзаганууд бөөгнөрсөн үед бодгаль хооронд халдвар дамжих нөхцөл бий болдог. Байгаль дээрх цусан суулга өвчнийг хянах найдвартай арга байхгүй байна. Гэрийн малын зарим хэлбэрүүдэд зориулсан вакцин бий боловч зэрлэг амьтанд тэдгээрийн нөлөөлөх байдал бүрэн судлагдаагүй, ямар ч тохиолдолд ашиглах хүндрэлтэй эсвэл боломжгүй юм. Бүдүүн эвэрт аргалийн хувьд *Ovis canadensis* –ийн бэлчээрт гэрийн мал бэлчихийг хязгаарлахад хяналтыг чиглүүлсэн. Иймэрхүү хандлагыг зарчмын хувьд бөхөн дээр ашиглах боломжтой, жишээлэхэд өвчин дамжих болон дамжих эрсдэлийг бууруулахын тулд янзаганууд бөөгнөрсөн үед гэрийн мал ойр бэлчихээс зайлсхийх хэрэгтэй. Энэ хэдийгээр бөхөнгийн популяцид хэвийн бус бактерийн нөлөөллийн дүнд үүссэн дэгдэлтийг зайлуулж чадаагүй ч төллөх үеийн үржлийн сүргийн ойролцоох хүн малын тоог багасгах нь стрессийг багасгах, үүнээс үүдэн өвчнөөс сэргийлэхэд туслаж болно. Бөхөнгийн тохиолдолд хаврын бөөгнөрөл сарних, зуны улиралд тэжээл сайжирсанаар хэрвээ үнэхээр цусан суулга гол шалтгаан нь байсан бол энэ онд амьд үлдэж чадсан амьтад цаашид цусан суулгын үхлийн тохиолдолууд хязгаарлагдах ёстой.

Цаашдаа, бөхөнгийн хувьд цусан суулга өвчний дэгдэлтэд чухам юу хүргэдэгийг сайтар ойлгох шаардлагатай. Өвчнөөс сэргийлэх сайжруулсан боломжууд нь нөхцөл байдлыг жолоодоход, жишээлэхэд хүнд өвлийн дараа нэмэлт тэжээл тавих, тус нэмэр болох юм. Бөхөнд нөлөөлөх иймэрхүү нөлөөллийг урьдчилан таамаглаж байх нь түүнийг хамгаалах бодитой зорилгуудыг тавихад тустай юм. Хэрвээ өвчнөөс үүдэлтэй их хэмжээний хорогдол нь бөхөнгийн хэвийн экологийн нэг хэсэг бол энэ нь өвчний ийм дэгдэлтийг бий болгодог эсвэл хүчийг нэмэгдүүлдэг хүний хүчин зүйлийн нөлөөг дээд хэмжээгээр хязгаарлах байдлаар түүнийг хамгаалах стратеги төлөвлөгөөнүүдэд тусгагдсан байх ёстой. Бөхөнд тархсан халдварт өвчнүүдийг илүү сайн ойлгохын тулд асуудлыг бүрэн судалсан байх ёстой боловч өвчлөлийг дэмжигч хүчин зүйлүүд муу судлагдсан байна. Түүнчлэн халдвар үүсэх боломжтой тохиолдлуудыг, жишээлэхэд цаашид бий болох тохиолдлуудыг шалгахад зориулсан материалуудыг хадгалах аргыг боловсруулахад анхаарах шаардлагатай. Үхсэн болон амьд бөхөнгүүдийн биеийн төлөв байдал, идэш тэжээлийн ургамлуудын өнөөгийн болон өнгөрсөн үеийн төлөв байдал, бөхөнгийн болон тэдгээрийн өвчнүүдийн орон зайн тархалт



Зургийг Республика КЗ.

Үхсэн бөхөнгүүдийн гэдэс нь хөөсөн байдал- цусан суулга өвчний түгээмэл шинж.

зэрэг экологийн хүчин зүйлсүүдийг эдгээр судалгаанд оруулсан байх ёстой.

Доктор Эрик Морган

Мал эмнэлгийн паразитологи, экологийн судалгааны групп
Бристоллын их сургууль, Их Британи
Eric.Morgan@bristol.ac.uk

МЭДЭЭ

БӨХӨНГИЙН НИЙТ ПОПУЛЯЦИЙГ СЭРГЭЭХ, ХАМГААЛАХ ТУХАЙ ХОЁР ТАЛЫН ЗӨВШИЛЦӨЛД УЗБЕКИСТАН БОЛОН КАЗАХСТАН УЛСУУД ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА

Ташкент хотноо 2010 оны 3-р сарын 17 нд Казахстаны ерөнхийлөгч Нурсултан Назарбаевын албан ёсны айлчлалын үеэр таван бичиг баримтанд гарын зурсныг Интерфакс агентлаг мэдээлж байна. Тухайлбал, Узбекистан улсын байгаль хамгаалах улсын хорооны дарга Нариман Умаров болон Казахстан улсын хөдөө аж ахуйн сайд Акылбек Куришбаев

БӨХӨН ХАМГААЛАХ ЭВСЭЛ БУЯНЫ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ЁСНЫ СТАТУСТАЙ БОЛОО

Бөхөн хамгаалах эвсэл 2010 оны 5-р сарын 10 нд албан ёсны буяны байгууллага болж, Англи болон Уэльсийн буяны байгууллагуудын хороогоор бүртгэгдэж эрх зүйтэй болов (№1135851). Энэ нь Бөхөн хамгаалах эвсэл Их Британид бүрэн эрхзүйн статустай болсон төдийгүй олон тооны төсөл авах хүсэлтээ гаргах боломжтой болсныг тэмдэглэж байна. Мөн түүнчлэн хандивлагчид биднийг хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага гэдэгт бүрэн итгэлтэй байж болохыг тэмдэглэж байгаа юм. Бөхөн хамгаалах эвслийн бүтэц, ажилчид, тогтоолын талаарх мэдээллийг www.saiga-conservation.com

нар бөхөнгийн популяцийн тогтвортой хөгжил, нөхөн төлжил, хамгааллын талаарх зөвшилцөлд гарын үсэг зурлаа.

Дэлгэрэнгүйг

http://www.interfax.kz/lang=rus&int_id=10&news_id=5121

интернэт хуудаснаас болон дарга (e.j.milner-gulland@imperial.ac.uk), гүйцэтгэх нарийн бичиг (esipov@xnet.uz)-ийн даргаас авч болно. Бөхөн хамгаалах эвслийн жил болгоны зөвлөлгөөнийг 2010 онд 9-р сарын 11 нд 14.00 цагт Залуучууд зочид буудалд (Улаанбаатар хот), SMS МоВ-ийн уулзалтын дараа шууд болно. Сонирхсон хүн бүрийг урьж байна. Хэрвээ Та уулзалтанд очихыг хүсвэл, зөвлөгөөний бичиг баримтыг илгээх, таны оролцоог зохион байгуулахын тулд бидэнтэй эртнээс холбогдоно уу!

КАЗАХСТАН УЛС БӨХӨНГИЙН АГНУУРЫН ХОРИОГ ДАХИН 10 ЖИЛЭЭР СУНГАХААР ЗЭХЭЖ БАЙНА

“Казахстанд бөхөнгийн агнуурын хориог 2021 он хүртэл сунгах болно” хэмээн республикийн хөдөө аж ахуйн яамны ой агнуурын хорооны даргын орлогч Хаирбек Мусабаев мэдэгдлээ. Түүний хэлсэнээр энэ зүйл амьтны тоо толгой 200

мянгаас багагүй болсон үед л бөхөнгийн агнуурын хориог цуцлах болно гэжээ. Казахстан дахь бөхөнгийн өнөөгийн тоо толгой ойролцоогоор 90 мянга орчим байна. (цааш харна уу) *Дэлгэрэнгүйг* <http://www.zakon.kz/173822-kazakhstan-nameren-zapreit-okhotitsja.html>

УЗБЕКИСТАНЫ ПАРЛАМЕНТИЙН ГИШҮҮД БӨХӨН ХАМГААЛАХ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭЖ БАЙНА

Узбекистаны экологийн хөдөлгөөний депутатуудын бүлэг болон Узбекистан улсын Олий Мажлиса хууль тогтоох ордны хүрээлэн буй орчны хамгаалал, экологийн асуудлаарх хороонохон “Арал тэнгис орчмын нийгэм, экологийн асуудлыг шийдэх зорилгоор олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах хэтийн чиг” гэсэн сэдвээр

дугуй ширээний хурал зохион байгууллаа. Хуралдааны явцад хэд хэдэн асуудлаар, тухайлбал экосистемийн доройтол, арал тэнгисийн гамшигийн нөлөөг багасгах, хилийн бүсийн усны эх үүсвэрүүдийг зохистой ашиглах, экологийн аюулгүй байдал, бүсийн тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр олон улсын

байгуулагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх саналуудыг боловсруулсан байна. Дугуй ширээний оролцогчид мөн НҮБ зэрэг нэр хүндтэй олон улсын байгууллагын дэмжлэг шаардагддаг экологийн иж бүрэн төслүүдийг хэрэгжүүлэхийг санал болголоо. Санал болгосон төслийн чиглэлүүдийн нэг бол

ургамал болон амьтны (бөхөнг оролцуулан) аймгийн популяциудийг сэргээх, тусгай хамгаалалттай газар нутгийн талбайг нэмэгдүүлэх зэрэг байв. *Дэлгэрэнгүйг* http://www.econews.uz/index.php?option=com_content&view=article&id=296:ecologists-have-united-in-the-decision-of-problem&catid=5:water-&itemid=15

ОХУ-ын байгалийн нөөц, экологийн сайд бөхөн хамгаалах шаардлагатайг цохон тэмдэглэв

Халимагт 2010 оны 4-р сарын 1-нд ОХУ-ын байгалийн нөөц экологийн сайд Юрий Трутнев нэг өдрийн ажлын айлчлал хийв. Түүний удирдлага дор Халимагийн Бүгд Найрамдах Улсын тэргүүлэгчид, засгийн газрын гишүүд, экологийн аюулгүй байдал, бөхөн хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах удирдлагын газруудын дарга нар оролцсон ажлын зөвлөлгөөн боллоо.

Зөвлөлгөөний явцад ОХУ-ын байгалийн нөөцийн яамны мэргэжилтэнүүд байгаль орчин дахь сөрөг нөлөөг бууруулах талаар авч үзсэн хуулийн төслүүдийн багцын талаар илтгэл тавилаа. *Дэлгэрэнгүйг* http://www.elista.org/elista_kalmykiya-s-rabochim-vizitom-posetil-ministr-prirodnih-resursov-i-ekologii-rf-yurii-trutnev.html.

Халимагийн их сургуульд бөхөнд зориулсан дугуй ширээний хурал боллоо

Халимагийн их сургуульд 2010 оны 3-р сарын 18-нд бөхөн хамгаалах асуудлаар дугуй ширээний хурал боллоо. Оюутнууд бөхөнгийн үржил, тэжээл, нүүдлийн зам, тоо толгойн динамикийн чиглэлээр илтгэлүүд бэлдэцгээв. Дугуй ширээнд бүсийн байгаль орчны яамны, “Черные земли” улсын байгалийн шим мандлын дархан газрын, зэрлэг амьтны төвийн төлөөлөгчид оролцлоо.

Засаг захиргааны өөрчлөлт, санхүүгийн хүрэлцээгүй байдлаас болж бөхөн хамгааллын зогсолт, хулгайн ан, мониторингийн асуудлуудыг хэлэлцэв. (Редакцаас: бөхөн хамгааллын бүрэн эрхийг хөдөө аж ахуйн яамнаас Байгаль орчны яаманд шилжүүлсэн). Бөхөн хамгаалах тусгай отряд байгуулах асуудал одоо болтол шийдэгдээгүй байна. “Халимагийн мэдээ” сонины материалаас 2010 оны 3-р сарын 20.

БӨХӨНГИЙН ЖИЛД ЗОРИУЛСАН ХАЛИМАГИЙН ЗАЛУУЧУУДЫН ЧУУЛГА

Халимагийн засгийн газрын хурлын зааланд 2010 оны 5-р сарын 28-нд бөхөнгийн жилд зориулсан “Экологи, Инноваци, Хүн” гэсэн бүс хоорондын залуучуудын экологийн чуулганы нээлт боллоо. Нээлтийн ажиллагаанд Халимагийн тэргүүн Кирсан Илюмжинов, Боловсрол соёл, шинжлэх ухааны сайд Бадма Салаев болон тус улсын, Өмнөдийн холбооны их сургуулийн эрдэмтэд оролцлоо.

Экологийн асуудлууд өнөө цагт маш чухал бөгөөд богино хугацаанд тэдгээрийг шийдвэрлэх хэрэгтэйг Халимагийн тэргүүн тэмдэглэлээ. Нээлтийн дараагаар завсарлах танхимд шинэ технологийн төслүүдийн үзэсгэлэн болж байлаа. *Дэлгэрэнгүйг* <http://www.elista.org/elista/v-elite-sostoyalos-tkryitie-molodezhnogo-ekologicheskogo-foruma.html>



Кирсан Илюмжиновын нээлтийн үг.



Бөхөн хамгаалалд зориулсан төслийн үзэсгэлэн дээр.

2010 ОНД КАЗАХСТАНД ХИЙГДСЭН БӨХӨНГИЙН АГААРЫН ТООЛЛОГЫН ДҮН

Бөхөнгийн жил бүрийн агаарын тооллогыг Казахстанд 2010 оны 4-р сарын 9-нөөс 5-р сарын 1-ны хооронд Казахын амьтан судлалын хүрээлэн, ой агнуурын улсын хороо, Охотзоопром, мужийн ой, агнуурын аж ахуйн хяналтынхан, Казахстаны биологийн олон янз байдлыг хамгаалах нийгэмлэгийн төлөөлөгчид оролцон гүйцэтгэлээ. Тооллогын дүнгээр бөхөнгийн тоо толгой 97.4 мянган бодгаль (2009 онд 81.0 мянган

бодгаль), үүнээс Бетпақдалийн популяци 53.4 мянга, Устюртийнх -4.9 мянга, Уралийн популяци 39 мянган бодгаль байна. Өмнөх жилтэй харьцуулахад Бетпақдалийн популяци, уралийн популяцийн хэмжээ нэмэгдсэн ч Устюртийнх багассан байна. 2010 оны 5-р сард цусан суулга өвчнөөр бараг 12.0 мянга бодгаль хорогдсоны дараа уралийн популяци 2009 оны түвшин (ойролцоогоор 27.0 мянга) хүртлээ буурсан байна. Иймд

Казахстаны бөхөнгийн нийт тоо энэ мөчид 85.3 мянга бодгаль байна.

БӨХӨНГИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ РАДИО ДОХИОЛОЛТОЙ ХҮЗҮҮВЧНИЙ ТУСЛАМЖТАЙ АЖИГЛАДАГ

Халимагийн бүгд найрамдах улсын зэрлэг амьтны төвийн суурь дээр телеметрийн арга ашиглан бөхөнгийн шилжилтийг судлах сонирхолтой чухал судалгааг хийж байна. Туршилтыг нэлээд хэдэн жилийн өмнө Висконсин мужийн их сургууль (АНУ), А.Н.Северцовын нэрэмжит экологи, эволюцийн судалгааны хүрээлэн оролцон эхлүүлсэн. Радиохүзүүвчнүүдийг National Geographic сангаас хандивласан байсан. 2009 оны 12-р сард хүзүүвчнүүдийг бөхөнгийн 3 оононд зүүсэн. Тэдгээрийг “Волга” амьтан үржүүлгийн фермийн ойролцоо бэлчиж байсан бөхөнгийн сүргээс холгүй суллаж тавьсан. Хүзүүвчтэй бөхөнгүүд зэрлэг сүрэгтээ

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл [Ю.Грачевт хандана уу](mailto:Ю.Грачевт@mail.ru)
teriologi@mail.ru

амжилттай дасан зохицсон. Туршилтын явцад бөхөнгийн ороо хөөцөөн явагддаг чухал газруудын нэг бол “Черные земли” дархан газрын орчны бүсийн хойд болон зүүн хэсэг болох нь тодорхой болсон. ОХУ-ын Астраханск мужийн “Степной” нөөц газарт Халимагийн зэрлэг амьтны төвд үржүүлсэн бөхөнгийн шаргачинг байгалийн жинхэнэ орчинд суллаж тавьсан. Авсан мэдээллүүд нь байгаль дээрх популяцийн илүү үр дүнтэй хамгааллыг явуулахад байгаль хамгааллын байгууллагуудад нэмэр болох байх. *Дэлгэрэнгүйг “Халимагийн мэдээ” 2010 оны 2-р сарын 6, № 20 болон <http://www.astrakhan.net/?ai=23488>*

ҮРЖҮҮЛГИЙН ГАЗАРТ ШИНЭ ЯНЗАГАНУУД ТӨРЛӨӨ

2010 оны 6-р сарын 22-ны “Интерфакс-Юг” агентлагийн мэдээлсэнээр Халимагийн бүгд найрамдах улсын зэрлэг амьтны төвийн ажилчид анх удаа бөхөнгийн төрөлтийн түвшинг нэмэгдүүлж чаджээ. “Энэ жил маш амжилттай байлаа: 40 гаруй шаргачингаас бид ойролцоогоор 35 янзага авсан нь үржүүлгийн ажлын сүүлийн 10 жилдэх хамгийн өндөр үзүүлэлт байсан. Өндөр өвстэй учраас янзаганы тоог нарийн гаргах боломжгүй байна учир нь үр төлөө

сэргийлсэн сүргүүд хүмүүсийг ойртуулахгүй байна. Гэвч өнгөрсөн жилийн төллөлтэй харьцуулахад энэ хаврын төллөлт бараг 2 дахин илүү” гэж төвийн захирал Юрий Арылов мэдээллээ. Ганьсюгийн (Хятад) ховор амьтныг үржүүлэх төвд 2010 онд 26 бөхөнгийн янзага гарсан байна. Тэдгээрийн хамт үржүүлгийн газарт бөхөнгийн нийт тоо 80 бодгаль хүрчээ. *Дэлгэрэнгүйг <http://news.xinmin.cn/rollnews/2010/07/18/5833748.html>*

“АЛТЫН-ДАЛА” ЗУРГИЙН ҮЗЭСГЭЛЭН

Казахстан дахь Германы жилийн хүрээнд 4-р сарын 29 нд Алмата хотноо “Алтын-дала” зургийн үзэсгэлэн нээгдлээ. Казахстаны биологийн олон янз байдлын нийгэмлэгийн энэ санаачлага нь тус улсын хээрийн болон заримдаг цөлийн экосистемийг хамгаалах, сэргээхэд уриалсан байв. Тухайлбал, Төв азийн хээрийн чимэг болсон бөхөнгийн Бетпақдалийн

популяцийг хамгаалах. ТХГН-т шинжилгээ судалгааны ажлууд, агнуурын аж ахуй, амьтны аймгийн хамгаалал, мониторингийн тухай, хууль бус агнууртай тэмцэх тухай ажлуудыг өгүүлсэн 10 мэдээллийн самбар, видео үзүүлбэрүүдээс үзэсгэлэн бүрджээ. Жилийн туршид хөдөлгөөнт үзэсгэлэн Казахстаны бүх хотуудаар аялах болно. *Дэлгэрэнгүйг <http://inform.kz./rus/article/2263579>*

ЕВРОПЫН ЗЭРЛЭГ БАЙГАЛИЙН ГАЙХАМШИГУУД

“Европын зэрлэг байгалийн гайхамшигууд” олон улсын байгаль хамгааллын зургийн төсөл уралдаан 2008 оны эхэнд эхэлсэн юм. 2 жилийн туршид 60 гаруй хамгийн нэр хүндтэй зурагчин-байгаль судлаачид энэ төсөлд оролцсон. ОХУ –ыг төлөөлж фотозурагчин Игорь Шпиленок Оросын дархан газрууд болон үндэсний паркууд гэсэн сэдвээр оролцсон. Баруун Хойд Прикаспийн бөхөнгийн популяци бол Игорь Шпиленокийн уран бүтээлд чухал үүрэгтэй байдаг.

Энэхүү өргөн хүрээний зургийн төслийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл <http://www.wild-wonders.com.html> болон Игорь Шпиленокийн сайтуудад http://shpilenok.ru/galleryru_8.html, <http://shpilenok.livejournal.com/6141.html> орно уу.

Редакцаас: Игорь Шпиленок- эртний хамтрагч-SCA-ийн найз. Тал нутгийн давтагдашгүй байгалийг магтан дуулсан тэрээр Халимагт олон жил ажилласан. Энэ гайхалтай зурагчины ажлууд Бөхөнгийн мэдээний хуудсуудыг чимж байдагт бид бахархаж байна.

УЗБЕКИСТАНД БӨХӨНГИЙН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭЛЭЭ

Узбекистаны бөхөн тархсан нутгуудад байрлах Устюртийн суурингуудад 4 дэх жилдээ бөхөнгийн өдрийг амжилттай тэмдэглэсээр байна. Бөхөнгийн өдрийн баяр хугацааны хувьд энэ амьтны үржлийн үетэй тохиодог бөгөөд төрөлх нутгийн байгалийг хамгаалах, үржил шимийг сэргээх баяр болдог байна. Энэ жил баяраа 4-р сарын 26-27 нд тэмдэглэсэн. Энэ баярыг зохион байгуулах, тэмдэглэхэд Жаслык, Каракалпак суурингийн иргэд, сурагчид, багш нар төдийгүй бөхөн хамгаалах эвслийн гишүүд оролцож WCN дэмжлэг үзүүллээ. Уламжлал ёсоор баярын эхэнд эхлээд гар зургийн уралдаан, уран зохиолын уралдаан болж 7-15 хүртлэх насны янз бүрийн хүүхдүүд оролцлоо. Шилдэг бүтээлийн эздийг SCA-ийн тусгай шагналуудаар хүндэтгэлтэй шагналаа. Хүүхдүүдийн хамгийн сонирхолтой, авъяаслаг зохиол бүтээлүүдийг бөхөнгийн тухай хүүхдэд зориулан бичсэн тусгай ном хэлбэрээр хэвлүүлэх болно.



зургийг А.Егорова

Устюрт дэх бөхөнгийн өдөр,

Тайлбар нь хүүхдүүдийн зургууд байх болно. Одоогоор хэвлэгдэх номын эхийг бэлтгэх ажил явагдаж байна.

Баярт оролцсон сургууль болгон өөр өөрийнхөөрөө бөхөнгийн өдрийг өнгөрүүллээ. Энд мөн хөгжилтэй уралдаан бүхий өрсөлдөөнт спорт тэмцээнүүдэд “Бөхөн” болон “Барс” багийнхан нэр төрөө хамгаалж оролцсон, биологи, байгаль хамгааллын чиглэлээр мэдлэгээ сорьсон асуулт хариултын оюуны тэмцээнүүд ч болсон. Хөгжөөн дэмжигчид өөрсдийнхөө багийг дэмжин заримдаа дэлхийн хөл бөмбөгийн аварга шалгаруулж буй мэт ширүүхэн болов. Багш сурагчдын бөхөн болон байгаль орчны сэдвээр бичсэн зохиомжоор театрчилсан жижиг жүжиглэлт, дуу, бүжиг тоглосон нь баярыг хэзээ ч мартагдахааргүй болголоо. Жаслык сууринд бөхөнгийн өдрийг өнгөрүүлэх хүрээнд урлаач, бүтээлч хүүхнүүдийн бүтээлийн үзэсгэлэн амжилттай боллоо (цааш харна уу).



Белеулы руу аялсан нь,

“Өмнө нь бидэнд бөхөн хамгаалах талаар тусгайлсан арга хэмжээ явуулах ямар ч туршлага байсангүй” хэмээн Каракалпак суурингийн 26-р сургуулийн захирал Ажимова Дина Болтаева өгүүлэв. “Бөхөн бол тал нутгаасаа салшгүй, Хүмүүс, бөхөн, тал нутаг гэдэг Дэлхий дээрх бүх зүйл холбоотой гэж би боддог, нэг

УРАЛД БӨХӨН ХАМГААЛАХЫН ТӨЛӨӨ “ХЭВТЭЭ АЖИЛ ХАЯЛТ ”

Уралын сэтгүүлчид 6-р сарын эхэнд 12 мянган бөхөн үхсэн шалтгааныг бодитой мөрдөхийг шаардаж цуглаан явууллаа. Уральск хотын төв талбайд хотын захиргааны үүдэнд үхсэн бөхөнгүүдийг дүрслэн харуулахаар 25 хүн гарч ирлээ. Цуглааны зорилго бол бөхөнгийн үхлийн шалтгааныг бодитой мөрдөхийг шаардах,

ОЛОН УЛСЫН САНГУУД ТУСЛАМЖЫН УРИАЛГАД ХАРИУЛАВ

Баруун–Хойд Прикаспийд бөхөнгүүд хатуу ширүүн өвөл болон хулгайн ангийн улмаас олноороо үхэх аюулын өмнө тулгараад байна. Бөхөн хүнд байдалд орсон шалтгаан бол мөсөн бүрхүүлтэй зузаан цас (зуд) юм. Зузаан цас энэ зүйлийг гэжээ олж идэх, шилжин явахыг хязгаарлах учир амьтад өлсөж үхэх, махчид болон хулгайн анчдаас зугтаж чадахгүй болсон (SN №10-г харна уу). WWF 200 гаруй мянган рубль цуглуулж, “Степной” байгалийн нөөц газар болон “Наш край” бүсийн экологийн байгууллага руу хууль бус агнууртай тэмцэхэд зориулж өгсөн. Одоогоор WWF энэ зүйлийн цаашдын урт хугацааны хамгааллыг дэмжих үүднээс компаниудтай гэрээ хэлэлцээр явуулж байна. Түүнчлэн, “Наш край” олон нийтийн байгууллага IFAW –ийн жижиг төслүүдийн хөтөлбөрөөр авсан 5 мянган доллараа бөхөн хамгаалах үйл ажиллагаанд зориулж Казахстаны байгаль

ОХУ-Д БӨХӨНД ЗОРИУЛСАН ТАЙВАН БҮС БАЙГУУЛЛАА

Бөхөнгийн амьдрах нутгуудад 2010 оны 4-р сарын 20-ноос 5-р сарын 31 хүртэл тайван бүс бий болгосон байна. “Черные земли” улсын шим мандлын дархан газар болон түүний



Каракал сургууль дээр болсон спортын тэмцээн

хэсэг нь түүнийг ариун амьтан хэмээн тооцож, бөхөн агнахыг нүгэл гэж байхад нөгөө хэсэг нь түүнийг устгаад л, хүмүүсийн бөхөнд хандах эсрэг тэсрэг хандлага намайг бүр гайхшруулж байна”. Энэ гайхалтай амьтныг хамгаалах сэдэв биднийг, багш нарыг, сурагчид, тэдгээрийн эцэг эхчүүдийг хөндөж чадсан. Сургуулиудад ажил явуулж эхэлсэн нь үнэхээр сайн. Энэ нь хүүхдүүдийн ухамсарт нөлөөлж, харин хүүхдүүд эцэг эхийнхээ ухамсарт нөлөөлөх болно. Биднийг сонсохгүй байж болно, харин хүүхдүүдийнхээ үгийг бол сонсдог”. 26-р сургуулийн багш нарын санаачилгаар Бөхөнгийн өдрийг суурингийн түвшинд явуулахыг санал болгож байсан. Энэ санааг Каракалпак болон Жаслык суурингуудын орон нутгийн захиргаан дээр хэлэлцээд дэмжсэн байна. Баярын дараагийн өдөр Жаслык суурингаас бүтээлч уралдаанд түрүүлсэн хүмүүс бөхөнгийн хуучин төллөх нутаг байсан дундад зууны үеийн балгас Белеулы руу аялсан. Сурагчид энэхүү дурсгалт газрын түүх, түүний амьдрал оршиж байсан системтэй танилцаж, түүний орчимд байх амьтдын тухай мэдэж, бөхөн болон бусад амьтдын амьдрах орчныг үзэж харцгаалаа.

мөн иргэний нийгмийг Баруун-Казахстан мужид болсон үйл явцад илүү идэвхтэй оролцохыг уриалан сэрээх байв. Засаг захиргаа тэдний энэ үйлдэлд анхаарлаа хандуулна гэдэгт сэтгүүлчид найдсан. *Дэлгэрэнгүйг* http://respublika-kaz.ya.ru/replies.xml?item_no=3136.

орчны яаманд өгсөн. “Наш край” мөн Лукойлоос авсан грантынхаа хэсгийг (200 мянган рублийн ойролцоогоор 1/3) Халимагийн Бүгд найрамдах улсад бөхөн хамгаалах боловсролын арга хэмжээ явуулахад зарцуулна. “Халимагийн мэдээ” сонин, 2010 оны 2-р сарын 20, № 30 (4756) болон “Засгийн газрын сонин” 2010 оны 3-р сарын 13, №24 (825). WCN мөн SCA байгууллагуудын шугамаар Их британи болон АНУ-аас хувь хандивлагчдаас Баруун Хойд Прикаспийд бөхөн аврах үйлсэд 2600 орчим доллар цугларсан байсан. “Степной” нөөц газарт хулгайн антай тэмцэх, нутгийн иргэдийн дунд ухуулгын арга хэмжээ авахад зориулж “Наш край” олон нийтийн байгууллагад мөнгийг шилжүүлсэн. *Дэлгэрэнгүйг* http://www.infox.ru/science/animal/2010/03/02/V_prikaspiyskom_snye_p.html.

ойролцоох нутгуудад хамгаалалтын тогтоосон горимыг алдагдуулсан аливаа аж ахуйн үйл ажиллагаа, тээврийн хэрэгсэл нэвтрэх, байгалийн нөөцийн яам

Халимагийн хүрээлэн буй орчин, энергийн хөгжлийн яам, дархан газрын захиргааны зөвшөөрөлгүйгээр аливаа хүмүүс оршихыг хязгаарласан. Халимагийн байгаль орчин болон дотоод хэргийн яамдуудын хамтын ажиллагааны тухай зөвшилцлийг биелүүлэх

ХУУЛЬ БУС АН, ХУДАЛДААГ ИЛРҮҮЛСЭН ТОХИОЛДЛУУД

Уралын популяци

2010 оны 2-р сарын 8.

Баруун Казахстан мужийн Жанибек районы шүүхээс хууль бусаар 4 бөхөн агнасных нь төлөө Казталовск районы иргэн А.Тайгаренов болон Жанибек районы иргэн С.Насенов нарт хоёр жилээр хорих ял оноосон. Хохирлыг (1 сая тенге) хулгайн анчдаар бүрэн төлүүлж, бууг нь хураасан. *Дэлгэрэнгүйг* <http://inform.kz/rus/article/2236120>.

Бетпақдалийн популяци

2010 оны 2-р сарын 17.

Карагандинск мужид 6 бөхөн агнасан хулгайн анчдыг саатуулсан байна. Ультауск районы Косколь суурингын Акшаль гэдэг газар хоёр эрэгтэй хууль бусаар бөхөн агнаж байсан байна. “Охотзоопром” –ын хяналтынхан ирэхэд хулгайн анчид нуугдахыг оролдож хөөцөлдөх үед тэдний машин онхолдсон байна. Аварийн газарт Ультауск районы егерь болон 21 настай оюутан нар саатуулагдсан байна. Саатуулагдсан хүмүүсээс бөхөнг болон зэвсэг, сумыг нь хурааж авсан. *Дэлгэрэнгүйг* http://old.minagri.gov.kz/news/index.php?ELEMENT_ID=7828
<http://kt.kz/index.php?lang=rus&uin=1138536468&chapter=1153510433>

2010 оны 3-р сарын 10

Казахстаны Костанайск мужийн Жангельдинск районы Тауш сууринд хоёр бөхөн агнасан хулгайн анчинг саатуулжээ. Ой агнуурын аж ахуйн мужийн удирдах газрын ажилтан хэргийн мөр болон сэжигтний саравчнаас батлах зүйлсийг илрүүлсэн байна. Баривчлагдсан этгээдээс хоёр бөхөн (ооно, шаргачин), бүртгэлгүй хоёр амтай ангийн буу, бор өнгийн толботой хутга, бөхөнгийн эвэр, цасан дээр явагчийг хураасан. Энэ хэргээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа. Учруулсан хохирлын нийт хэмжээ 454-550 тенге (ойролцоогоор 3000 доллар АНУ). *Дэлгэрэнгүйг* <http://inform.kz/rus/article/2246513>.

2010 оны 6-р сарын 2.

Костанайск мужийн өмнөд хэсэг, Джангельдинск районы Акколь суурингаас баруун тийш 53 км-т 31 ширхэг бөхөнгийн сэг зэм илрүүлсэн байна. Хэргийн газраас шинжилгээ авахын тулд 2 сэгийг авч, бусдыг нь шатаасан. Харамсалтай нь амьтдын үхлийн шалтгааныг лабораторийн шинжилгээний дүнгээр тогтоож чадсангүй. Эд эсүүд нь муу хадгалагдаж үлдсэн учраас зөвхөн боомын шинжилгээ хийхэд сөрөг гарсан байна. Энэ тохиолдолд олноор нь хулгайгаар агнасан л болж таарч байна. Үүнийг батлах мэт бүх бөхөнгүүдийг эврийг хөрөөдөж авсан байв. Энэ хэргийг мөрдөх арга хэмжээ явагдаж, учруулсан хохирлын хэмжээг тогтоож байна.*Дэлгэрэнгүйг*

<http://today.kz/ru/news/kazakhstan/2010-06-18/22871>; <http://kt.kz/?lang=rus&uin=1138536468&chapter=1153519833>.

Устюртийн популяци

2010 оны 2-р сарын 21

Казахстаны Актюбинск мужийн Уилск районы Акшатау тосгонд хууль бус агнуурын баримт илрүүлсэн байна. Дотоод хэргийн байгууллагуудад Темирск болон Уилск районуудын 30-54 хүртлэх насны 5 хүнийг 4 бөхөн агнасан хэргээр хүргэгдсэн аж. Хулгайн анчдыг Актюбинск мужийн амьтны аймгийн эргүүл хяналт шалгалтын ажилчид саатуулан Уилскийн дотоод хэргийн газарт хүргүүлсэн. Тэднээс гурван буу,

хүрээнд дурьдсан нутгуудад цагдаагийн ажилтнууд, байгаль орчны хяналтынхан хамтарсан эргүүл шалгалтыг зохион байгуулсан. “Халимагийн мэдээ” сонин 2010 оны 4-р сарын 24.

сумнууд, 2 хоёр нүдний дуран хураасан байна. Энэ хэрэгт 288-р зүйлээр (хууль бус ан) эрүүгийн хэрэг үүсгэсэн. *Дэлгэрэнгүйг*

<http://news.gazeta.kz/art.asp?aid=141681>

2010 оны 3-р сарын 24

Кунград –Бейнеу №917 галт тэргэнд ямарч бичиг баримтгүйгээр эвэр авч явсан Каракалпақстаны Кунград районы Каракалпакия тосгоны иргэнээс бөхөнгийн шинэвтэр байдлаараа янз бүр 8 эвэр хураан авчээ. Хэргийн материалыг Аральскийн байгаль хамгаалах прокурор луу шилжүүлсэн. Тээврийн цагдаа болон Каракалпақстаны байгаль хамгаалах хорооноос дээрх иргэнийг саатуулсан.

2010 оны 4-р сарын 4

Узбекистаны Ташкент мужийн Гишт-Куприк гаалийн удирдлагын гааль дээр 119 ширхэг бөхөнгийн эвэр бүхий цүнх илрүүлсэн байна. Цүнхний эзэн хууль бусаар эврүүдийг Казахстаны нутаг руу авч гарах гэсэн боловч чадаагүй учир хаясан гэж таамаглаж байна. Энэ хэргийн материалыг мужийн прокурорийн газар луу авч үзэхээр шилжүүлсэн. *Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл А.Есиповт хандана уу* esipov@xnet.uz



зургийг Ташкент мужийн гаалийн удирдлага

Узбекистанаас Казахстан руу гаргахыг завдсан бөхөнгийн эврүүд

Баруун Хойд Прикаспийн популяци

2010 оны 3-р сарын 11

ОХУ-ын Халимагийн аюулгүй байдлыг удирдах болон СКП мөрдөх товчооны хамтын ажиллагааны явцад Элиста-Лагань төв замаас холгүй Черноземелийн дотоод хэргийн ажилтныг саатуулах үед машин дотор нь 19 агнасан бөхөн илрүүлсэн байна. Дотоод хэргийн тасгийн ажилтнаас гадна машинд өөр гурван иргэн байв. Үзлэгийн явцад бөхөнгийн гулуузнуудад сумны нүхнүүдтэй, бүгдийнх нь хоолойг хэрчсэн байсан. “Сайга” карабин бууг хураасан. Энэ хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэгдсэн. Халимагийн дотоод хэргийн газрын хэвлэлийн албаны мэдээгээр цагдааг дотоод хэргийн байгууллагаас халсан байна. *Дэлгэрэнгүйг* www.regnum.ru/news/accident/1263709.html
<http://www.regnum.ru/news/accidents/1263709.html>.

ОХУ-ын Волгоград мужийн Палласовск районы Эльтон тосгонд хилийнхэн машин зогсоход бөхөн агначихсан, буу авч явж байхыг илрүүлжээ. Машины салонд бөхөнгийн мах, буу авч яваа шалтгааныг тодруулах явцад саатуулагдсан нөхдүүд хэргийн газраас зугтахыг оролдсон. Хоёр цаг гаран автомашинаар хөөцөлдсөний эцэст саатуулсан байна. Саатуулах үед жолооч болон зорчигч хоёр хилчинд биеэрээ эсэргүүцэл илэрхийлсэн. Одоогоор энэ хэргийн бүх материалуудыг Волгоград мужийн захиргааны агнуурын удирдах газрын агнуурын аж ахуй, амьтны аймгийг хамгаалах хэлтэс рүү цаашид эрүүгийн хэрэг үүсгэх тухай цаашдын шийдвэрийг гаргуулахаар шилжүүлсэн. Дэлгэрэнгүйг [http:// v1.ru/newsline/274670.html](http://v1.ru/newsline/274670.html).

2010 оны 4-р сарын 22

Зам тээврийн хяналтын Элистинскийн постон дээр замын байцаагчид агнасан бөхөн болон бөхөнгийн 20 эвэр тээж явсан автомашиныг саатуулжээ. Хэргийн баримтуудыг хурааж мөрдлөгө явуулж байна. “Халимагийнн мэдээ” сонин, 2010 оны 4-р сарын 27

Хятад

2010 оны 5-р сар

Шензен дэхь Хуанган гааль дээр нийтдээ 650 мянган



Photos by Anatoly Khludnev

Хулгайн анчдын агнасан бөхөнгийн ооно

юанийн (ойролцоогоор 100000 доллар АНУ) өртөг бүхий бөхөнгийн 22 эвэр хураажээ. Ховор зүйлийн эврийг Гонконгоос хууль бусаар гаргах гэсэн хэргээр хоёр сэжигтэнийг баривчилж, эрүүгийн хэрэг үүсгэжээ. Дэлгэрэнгүйг [http:// news.dayoo.com/shenzhen/201005/12/73439_12745992.html](http://news.dayoo.com/shenzhen/201005/12/73439_12745992.html)

ӨГҮҮЛЛЭГҮҮД

МОНГОЛ БӨХӨН (SAIGA TATARICA MONGOLICA) ГЭРИЙН АМЬТДЫН ӨВЧНҮҮДЭД ӨРТӨМТГИЙ БОЛОХ НЬ.

Шийлэгдамба Э¹, Файн А.Е¹, Бүүвэйбаатар Б², Лхагвасүрэн^{2*} Б., Муррей К¹, Бергер Дж.¹

¹ Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг, Монголын Шинжлэх Ухааны Академийн Биологийн хүрээлэн,*

WWF- Монгол, eshiilegdamba@wcs.org

Монгол бөхөн (Saiga tatarica mongolica) бол Баруун Монголын Алтай-Саяны бүсийн эмзэг зүйлүүдийн нэг юм. WWF- Монгол болон Биологийн хүрээлэнгээс хийгдсэн судалгаануудын хүрээнд монгол бөхөнгийн нийт толгой 1998 онд 2950 бодгаль, 2000 онд 5240 бодгаль байжээ. Шаргын дархан газар болон түүний орчимд хийгдсэн сүүлийн үеийн судалгаануудаар тоо толгой 2006 онд 4524 км² нутагт 4938 (95% хяз. 2762-8828) бодгаль, 2007 онд 4678 км² нутагт 7221 (95% хяз. 4380-11903) бодгаль нөөцтэй болохыг гаргасан. Хэдэн жилийн туршид монгол бөхөнгийн тоо толгой буурсан нь байгалийн хүчин зүйлүүдийн нөлөө, тоо толгойн байгалийн хэлбэлзэл, бэлчээрийн талхагдал, агнуурын

нөлөөнөөс үүдэлтэй. Бодитой аюулын тоонд ч мөн бөхөнд гэрийн малаас өвчин халдах аюулыг тооцож үзэхийг санал болгож байсан байна. Хэвлэлийн бүтээлүүдэд харахад монгол бөхөнгийн өвчин эмгэгийн талаарх мэдээлэл хангалтгүй байна. Иймээс гэрийн хивэгч амьтдын халдварт өвчнүүдээр монгол бөхөн өвчлөх түвшинг урьдчилан судлах нь өвчлөлийн байдал, тэдгээрийн зэрлэг амьтанд дамжихаас сэргийлэх судалгаанд шийдвэрлэх эхний алхамууд болох юм. Гэрийн малын ойр бэлчиж байсан бөхөнгүүд гэрийн амьтдаас халдвар авах боломжтой гэсэн таамгыг Казахстан эрдэмтэд дэвшүүлсэн. Казахстанд тест хийж үзсэн бүх үнээ, хонь, ямаанд шүлхийн вирус (FMD), цэнхэр хэлний өвчний вирус (BTV), халдварт геморрагический таталтын вирус (EHFV), жижиг хивэгчдийн тахлын вирус (PPRV) болон бруцеллезын вирус олдсон нь энэ бүсэд гэрийн амьтдаас зэрлэг амьтанд эдгээр өвчнүүд дамжих өндөр магадлалтайг Лундэрвольд (2004²) мэдээлсэн. Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг, ШУА-ийн Биологийн хүрээлэнтэй хамтран 2006 оны 8-р сард Шаргын дархан газарт анхлан бөхөнд радиодохиололтой хүзүүвч зүүсэн (Saiga news №4). Ажлын зорилго бол бөхөнгийн шилжилт, мэнд үлдэлтийг судлахад оршиж байсан. Бөхөн барих үедээ 8 бодгалийн (7 шаргачин, 1 янзага) гүрээний судаснаас цусны дээж авч ийлдэсийг ялгав. Дээжнүүдийг Монголд - 20° температурт 2009 оныг хүртэл хадгалж байгаад Америк руу Корнельскийн их сургууль болон мал эмнэлгийн



Зурвалж К. Муррей

2006 онд радио дохиололтой хүзүүвч зүүх төслийн үеэр монгол бөхөн барьж буй нь .

² www.iccs.org.uk дээр докторын ажлыг олж болно.

Коллежийн амьтны өвчнийг шинжлэх төв рүү судалгаанд зориулж хөлдөөсөн хэлбэрээр явуулсан. Ийлдэсийн дээжнүүдийг Монголд энгийн байдаг гэрийн малын өвчнүүд тухайлбал, шүлхий (FMD), “хонины хөх хэлний” вирус (BTV), үхрийн вирусийн диарей (BVD), үхрийн амьсгал-синциталь вирус (BRSV), үхрийн парагриппийн вирус, хэлбэр 3 (PIV 3), контагиозный эктим (Orf), лептоспироз (9 серологийн дээж), бруцеллез болон паратуберкулезнуудад (Джоны өвчин) шалгаж үзсэн. Гурван бодгаль дээр өвчнүүд илэрсэн. Найман монгол бөхөнгөөс хоёр нь шууд бус иммунофлуоресцентийн тестээр контагиозны эктимээр халдварласан (нэг бие гүйцсэн нь сулхан эерэг реакцтай, нөгөөх нь халдварласан байх сэжигтэй), харин нэг бодгаль (бие гүйцсэн шаргачин сулхан эерэг реакцитай) парагрипп (PIV 3) вирусаар халдварласан байна. PIV 3 бол гэрийн хивэгч амьтдын дунд өргөн тархсан өвчин юм. Халдвар нь үхэр, хонь, ямаанд ихэнхдээ хурдан тархдаг. PIV-3 аар халдварласан амьтдад ихэнхдээ дахин бактерийн гаралтай үрэвсэл үүсэж хэрвээ эмчлэхгүй л бол үхэлд хүргэдэг. Контагиозный эктим (амны хөндийн үрэвсэл) бол хонь ямаанд тохиолдох энгийн өвчин бөгөөд хүнд халдварладаг, дэлхий дээр өргөн тархалттай юм. Энэ өвчин мөн цаа буга болон хонин буханд (*Ovibos moschatus*) тэмдэглэгдсэн. Халдварласан амьтдад

дархлаа нэг эсвэл хэдэн жилд бий болох авч халдварлаагүй бодгалиудын дунд өвчлөлийн түвшин өндөр (80%). PIV-3 коронар судас болон нүдний салслаг бүрхүүл, гадаад бэлэг эрхтэн, хөхний товчны гэмтэл бий болгодог боловч үхэлд хүргэх нь гэрийн амьтдын хувьд бага. Гэрийн амьтдын зарим төрлийн өвчнүүдэд монгол бөхөн өртөмтгий болохыг судалгааны үр дүнгүүд харуулав. Судалгаанд авсан дээжнүүд цөөн тоотой учир бөхөнгийн бүх популяцийн өвчлөлийн тухай дүгнэлт хийх боломжгүй юм. Монгол бөхөн тухайн судалгаанд авч үзсэн халдварт өвчнүүдэд өртөх боломжтой. Гэрийн малын өвчнүүдээр монгол бөхөн халдварлах түвшинг үнэлэхэд зориулж илүү нарийн бүрэн судалгааг явуулах шаардлагатай. Гэрийн малын өвчлөлийн байдал, зэрлэг амьтдын төлөв байдлыг сайн ойлгосноор халдварт өвчин дэгдэх аюулаас монгол бөхөнгийн популяцийг сэргийлэх, жолоодоход зохих арга хэмжээг ашиглах боломжийг судалсанаар монгол бөхөнгийн популяцийг халдварт өвчнөөс сэргийлнэ.

Судалгааг WCS болон Үндэсний газарзүйн нийгэмлэгийн санхүүгийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэсэн. Хээрийн ажлуудыг АНУ хөдөө аж ахуйн хэлтсийн малын эмч доктор Мишель Данбэр, малын эмч З.Намиш нар хийсэн.

“АСТРАХАНСКОЕ” УЛСЫН ТУРШИЛТЫН АНГИЙН АЖ АХУЙ ДАХЬ БӨХӨНГИЙН ҮРЖҮҮЛЭГ

Франов Н.А., Гагарин В.В.

ФГУ ГООХ “Астраханское”, nfranov@rambler.ru

ОХУ-ын хөдөө аж ахуйн яамны агнуурын хэлтсээс 2001 онд “Астраханское” улсын туршилтын агнуурын аж ахуйн суурь дээр “Сайгак” үржүүлэх асрах төв байгуулах шийдвэр гарсан байсан. Одоогоор үржүүлэх асрах ажил бөхөнг хүний халамжинд үржүүлэх замаар түүний генофондыг хадгалахад чиглэсэн. Тоо толгойг тогтвортой өсгөж чадсан тохиолдолд янз бүрийн нас хүйсний бодгалиудыг системтэйгээр буцааж байгальд нь тавихаар төлөвлөж байна. Эхэндээ үржүүлгийн газар 2.5 x 10 м –ийн бодгалийн, болон 180 x 180 м-ийн шаргачин янзаганы гэх мэт хашаануудтай 4 га талбайг эзлэж байсан. Хоёр жилийн дараа үржүүлгийн газарт өөрчлөлт хийж нийт талбайг 21 га хүртэл нэмэгдүүлж, амьтан байрших нөхцлийг сайжруулсан. Одоо үржүүлгийн газарт халхавч бүхий хэд хэдэн хашаа (5x9 м), халхавчгүй хэд хэдэн хашаа (10x9 м), ороо хөөцөөн явуулахад зориулсан 3 хашаа (0.5-1 га), ооно, шаргачин янзаганууд байхад зориулсан 2 том хашаа бий. Үржүүлгийн газарт амьтдад хагас идэвхтэй хариулгын систем ашигладаг. Бүх эр бодгалиудыг 4-5 сарын настайгаас нь эхлэн жилийн туршид тусад нь уужуу хашаанд байлгадаг. 10-11-р саруудад энэхүү оонуудын сүргээс 4 үндсэн, 4 нөөц оонуудыг барьж ороо хөөцөөнд оруулахын тулд тус бүрт нь 4 шаргачин бүхий бодгаль хашаануудад байршуулдаг. 2-р сард үржилд оролцсон оонуудыг дахин бусад оонуудын сүрэгт нийлүүлэн гаргадаг. Ороо хөөцөөн болсон хашаандаа л төрөлт болно. Төрсний дараахан, янзагануудыг тэмдэглээд янзага бүхий шаргачингуудыг барилгүйгээр (хөндлөвчүүдийг нээх замаар) нэг болгон нэгтгэж байгалийн ургамал бүхий уужуу хашаанд шилжүүлдэг. Орооны дараа шууд шаргачингуудыг нэгтгэх нь шинэ төрсөн янзагануудыг илрүүлэх, тодорхой шаргачин тэдгээрийн хамаарах байдлыг тогтооход хүндрэлтэй байдаг. Томоохон хашаануудад амьтдыг бодгаль бүрээр нь барих, жин болон мал эмнэлгийн шаардлагатай үзлэгийг хийхээр тэжээл бүхий амьд баригчаар тоногдсон. Сайн өвс ургамалтай том хашаануудад том сүргээр амьтдыг байлгах нь эерэг дүнг өгсөн. Нэгдүгээрт, янзага төрсөн цагаасаа л тэжээлдээ олон төрлийн өвс ургамал хэрэглэж эхлэх учир бүрэн хөгжилд нь тустай.



зургийг В.Гагарин

Одоохондоо түүнд зөвхөн дугаар л байна, харин дуудах алдрыг хүртэх хэрэгтэй

Хоёрт, хөхүүл үедээ шаргачингууд ногоон тэжээлийг шаардлагатай хэмжээгээр хэрэглэх боломжтой байдаг, гуравдугаарт, том талбай бүхий хашаа амьтдад хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх ач холбогдолтой. Үржлийн бодгалиудын тэжээлд зориулж нэлээд хэдэн жилийн туршид царгас өвс, шинэхэн хадсан алаг өвс, буталсан арвай, долоох хэлбэрээр эрдсийн нэмэлт, шүүслэг өвснүүд ашигласан. Тэжээх өртгийг бууруулах зорилгоор шүүслэг тэжээлүүдийг хасах туршилтыг явуулсан. Амьтдын зан төрх, эрүүл мэндийн байдалд ажиглалтаар ямар ч өөрчлөлт илрээгүй. Шүүслэг тэжээлийн үнэ нийт тэжээлийн үнийн 75%-г бүрдүүлдгийг тооцон түүнээс татгалзсанаар тэжээлдэх зардлаа нэлээд хэмжээгээр бууруулсан. Одоогоор нэг бие гүйцсэн бодгальд өвлийн улиралд хоногт 1 кг арвай, 2.5 кг өвс тавьдаг. Тэжээх өртгийг бууруулах цаашдын ажил янз бүрийн нас хүйсний амьтдад арвайн оптимал хэмжээг бүрдүүлэхэд орших болно.

Үржүүлгийн газрын гол асуудал бол хурц хэлбэрээр үе үе дэгддэг цусан суулга өвчин бөгөөд өвчнөөр үхэх хүртэл хэдхэн цаг болдог учраас өвдсөн амьтныг илрүүлэх, тэр битгий хэл эмчлэх ч боломжгүй байдаг. Үүний улмаас тоо толгой нь өсөөгүй. Үржүүлгийн газарт үхсэн амьтдаас судлаж үзэхэд *Pasterella multocida* В болон D хэлбэрийн өсгөрүүд илэрсэн. Үүнд 3-4 сарын настай үхсэн янзаганд зөвхөн D хэлбэр ялгарсан харин бие гүйцсэн бодгалиудаас энэ хоёр хэлбэр хоёулаа илэрсэн. Ид төллөлтийн дүнд эсвэл шинэ төрсөн янзагануудыг нэмж авчирч (2003 болон 2007 онуудад) 5-6 саруудад тоо толгой нэмэгдсэн ч янзаганы нэлээд хэсэг, бие гүйцсэн бодгалийн зарим нь үхэж 11-12 саруудад тоо толгой буурдаг. 9-р сараас 5-р сар хүртэл үржүүлгийн газарт үхэл хорогдол бараг гардаггүй. Бөхөнгийн тоо толгойн хөдлөлзүйг онуудаар 1-р хүснэгтэд харуулав.

1-р хүснэгтээс харахад үржүүлгийн газрыг байгуулсанаас хойших эхний хоёр жилд бөхөнгийн үхэл өвчнөөс болон гэмтэлээс үүдэн өндөр байсан. Дараагийн хоёр жилд үржүүлгийн газар дахь хүчин зүйлсийн бүрдлийн нөлөөнд тогтвортой тоо толгой бүрэлдэх болон чиглэлт бус зохиомол шалгарлын үр дүн болж төрөлт нь хорогдлоо нэлээд давсан. Цаашдаа тоо толгойн өсөлт болон хорогдлын үзүүлэлтүүд бараг тэгширсэн. Хорогдлын ихэнх тохиолдлууд цусан суулга өвчинтэй холбоотой. Иймээс халдвар үүсгэгчид орчинд хуримтлагдаж, төрсөн янзагануудаар дажин шинэчлэгддэг гэж таамаглаж байна. Хөдөө аж ахуйн амьтдад зориулсан цусан суулгын эсрэг вакциныг ашиглахад эерэг дүн гараагүй. Вакцинуулах процесс амьтныг барихтай холбоотой бөгөөд энэ үед амьтад хүчтэй стрессэд орох, заримдаа гэмтэл авдаг учраас вакцинжуулахаас түр татгалзах шийдвэр гарсан. Үржүүлгийн газрын захиалгаар 2009 онд үржүүлгийн газрын амьтдаас шууд авсан өвчин үүсгэгчийн дээжнүүдийг ашиглан туршилтын цусан суулгын эсрэг вакцины эхийг бэлтгэсэн. Хэд хэдэн бодгалиудад амжилттай туршсаны эцэст 2009 оны 12-р сард бүх бодгалиудад тарилга хийсэн. Түүнчлэн 3 долоо хоногос дээш настай янзаганууд болон шаргачингуудад эрүүл ахуйн үүднээс антибиотикүүд өгөв. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад янзаганы мэнд үлдэлт бараг 2 дахин нэмэгдэх боломж олгосон (хүснэгт 2). Үржүүлгийн газрын бөхөнгийн анхдагч тоо толгой 2003 онд байгалиас нь 50 янзага барьсанаар бүрэлдсэн. 2007 онд дахин бөхөн барьж нийлүүлсэн. Бөхөнгийн шаргачингууд амьдралынхаа эхний жилд бэлэг боловсроно, харин оонууд зөвхөн 1.5 насандаа бэлэг боловсордог. Иймээс үржүүлгийн газарт анхны ороог явуулахад Москвагийн зоопаркаас авчирсан бие гүйцсэн оонуудыг ашигласан. Дараа жилдэх ороонд үржүүлгийн газарт өсгөсөн оонуудыг оруулсан. Одоо үржүүлгийн газарт анхны барьж тавьсан бөхөнгөөс 7 настай 2 шаргачин амжилттай үржиж байна. 2008 оноос үржүүлгийн газарт ороо хөөдөөнд зориулж 4 ургийн шугамыг ялгасан. Ийм замаар тоо толгойн генетик олон янз байдал нэмэгдэх, байгалиас нь амьтад барих шаардлага багасах юм. Үржүүлгийн газарт ургийн цөмийг бүрдүүлэхийн тулд



Photo by Vyacheslav Gagarin

Үржүүлгийн төвд өссөн бөхөнгүүд бүр номхон ч болж чаддаг

эхний ээлжинд хүнд эерэг эсвэл саармаг үйлдэлтэй бодгалиудыг шалгаруулах нь чухал. Үйлчилгээний хүмүүст сайн сонирхож ханддаг бөхөнгүүд илүү тогтвортой сэтгэлзүйтэй болж, гэмтэж бэртэх нь бага байдаг. Үргэмтгий, мэдрэмтгий амьтдыг нийт сүргээс тусгаарлахгүй бол эмх замбараагүй байдал үүсдэг. Өвчтэй бодгалиудын эмчилгээ, сэргийлэлт амьтадтай нягт холбоотой байх шаардлагатай. Хүмүүст эерэг хандлагатай амьтдыг барих, тэмдэглэхэд амархан байдаг. Барилтын үед тэд стресст бага өртөж, дараа нь амархан сэргэдэг. Хүнд эерэг хандлагатай бөхөнгүүдийг уудам хашаанд хүнд сөрөг хандлагатай бөхөнгийн сүргүүдтэй нийлүүлэхэд тэдгээрийн зан төрхийн онцлогийг хурдан хүлээн авч, үйлчилгээний хүмүүсээс зугтдаг болж эхэлдэг нь үржүүлгийн газарт өсгөсөн бөхөнгүүдийг байгалийн популяци руу нь буцааж тавих боломжгүй тухай үл итгэгчдийн санааг няцааж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Үржүүлгийн газрын цаашдын ажил бөхөн үржүүлэх технологийг сайжруулахад чиглэх бөгөөд үүнд 2-3 жил шаардагдана. Хоёр гол чиглэлээр ажлаа явуулна: үржүүлгийн нөхцөл дэхь тоо толгойг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний өөрийн өртгийг бууруулах. Генетикийн олон янз байдлыг нэмэгдүүлэхийн тулд бөхөнгийн үржүүлэг явуулдаг газруудын хооронд оононы солилцоо хийхээр төлөвлөж байна. Тоо толгой нь тогтвортой өсөх үед байгаль дээр нь системтэйгээр буцааж тавих, мөн бусад үржүүлгийн газрууд руу шилжүүлэх ажлыг зохион байгуулна. “Астраханское” улсын туршилтын агнуурын аж ахуй бөхөн үржүүлэх чиглэлээр сонирхсон байгууллага, хувь хүмүүстэй хамтран ажиллахад бэлэн байна.

Хүснэгт 1. Үржүүлгийн газар дахь бөхөнгийн тоо толгой

	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Жилийн эхэндэх тоо толгой	0	34	21	24	34	40	37
Үржүүлгийн газарт төрсөн	0	7	13	17	25	25	21*
Байгалиас нь барьсан	50	0	0	0	35	0	0
Өөр замаар барьсан	2	0	0	0	0	0	0
Өнгөрч буй жилдэх хорогдол	18	19	8	7	50	28	21
Бусад үржүүлгийн газар луу шилжүүлсэн	0	2	2	0	4	0	2

*3 группээс (13 шаргачин) авсан төл, 4-р групп (5 шаргачин) хээл аваагүй учир жилд авах янзаганы тоог 8 бодгалиар дугуу авахад хүргэсэн.

Хүснэгт 2. Сүүлийн 5 жилийн хугацаандах үржүүлгийн газрын зоотехникийн ажлын зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2005	2006	2007	2008	2009
Шаргачингуудын дундаж нас	1.72	2.16	2.16	2.55	2.92
Нэг шаргачинд ноогдох янзаганы дундаж тоо	1.36	1.41	1.44	1.44	1.61
Жилийн эцэст янзаганы мэнд үлдэлт	М.б	М.б	52%	36%	61,9%

ЗҮҮН ХОЙД ПРИБАЛХАШ (КАЗАХСТАН) БОЛ ЗҮЙЛИЙН ДЭЛХЭЦ НУТАГ ДАХЬ БӨХӨНГИЙН (*SAIGA TATARICA TATARICA*) ХАДГАЛАГДАЖ ҮЛДСЭН БАС НЭГЭН АМЬДРАХ ОРЧИН

Жатканбаев А.Ж.

Казахстаны амьтан судлалын хүрээлэн, wildlife@nursat.kz

1990 болон 2000 оны эхэн үед маш олон тоогоор тогтмол тааралддаг байсан Зүүн Хойд Прибалхашд бөхөн одоо байдаг талаар баталгаатай мэдээлэл өнөөг хүртэл хэвлэгдэж байсангүй. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд бөхөнгийн тоо толгой асар ихээр (98% хүртэл) багассан ч бөхөн энэ бүсэд цөөн тоогоор байршсаар л байна. Дэлхэцийнхээ хязгаар хэсэгт, Бетпакдалийн үндсэн популяцаас зүүн тийш алслагдамал нутагт жижиг сүрэг, цөөн бодгалиар мэнд үлдсэн байна. Саяхан бид Өмнөд Прибалхашд газарзүйн хувьд тусгаарлагдсан тогтвортой сүргүүд байгааг тэмдэглэсэн билээ (SN №8 харна уу).

Зүүн хойд Прибалхашт 2009 оны 6-р сарын сүүлч, 7-р сарын эхээр автомашинаар маршрутын судалгаа хийлээ. Бид хүн бага суурьшсан, зэлүүд нутгаар маршрутаа (480 км) зохиосонюм. Актогай-Саякийн төмөр зам болон хий дамжуулах хоолойн салаа хоорондох нутгуудад бидэнтэй хоёр удаа бөхөн тааралдсан. Эхний сүргийг Балхаш нуурын зүүн үзүүрээс зүүн хойш 40 кмт Балхаш-Алакольской хотгорт 6-р сарын 25 нд тэмдэглэсэн. Хоёр бие гүйцсэн шаргачин, хоёр ооно, хоёр өнгөрсөн жилийн залуу бодгалиудаас сүрэг бүрдэж байсан. Бодгалиуд бараг тэгш тал дээр нэлээд нягт сүргээр бэлчиж байлаа. Автомашин 300-350 мойртох үед бөхөнгүүд зугатав. Дараагийн өдөр бид өөр нэгэн бөхөнгийн сүргийг (нэг томоохон ооно, 2 шаргачин, 3 залуу бодгалиуд) анхны амьтад тааралдсан газраас 5 км зайд ойролцоо газарт тэмдэглэсэн. Тэдэн лүү автомашинаар ойртох үед 1.5 км зайнаас бөхөнгүүд идэшлэхээ больж, аажуухан байрнаасаа хөдөлж, 500 м ойртох үед зугатаж эхэлсэн. Энэ бүсийн газар нутаг тэгш талархаг, алсаас сайн харагддаг (2-3-аас 5-7 км хүртэл). Иймээс хурдан явдаг бүрэн тоногтой машинаар 300-500 м-ээс илүү ойртоно гэдэг хүмүүсийн хувьд маш хэцүү. Энэ нь бөхөнгийн жижиг сүргүүдэд мэнд үлдэх боломж

олгосон амьдрах орчны таатай нөхцлүүдийн нэг болно. 100 км-ийн тууш хий дамжуулах хоолой дундуур амьтад шилжин гарах ямар нэгэн тусгай гарц байхгүйг бид ажигласан. Төмөр замын дэр моднуудын доогуур зарим газраар машин болон мал хөөж гаргахад зориулсан арк хэлбэрийн гарцууд байсан. Гэсэн хэдий ч энэхүү ховор ашиглагддаг мухар төмөр замын салаан дээр вагонтай мөргөлдөж үхсэн хоёр тэмээний сэг тааралдаж байв. Одоогоор төмөр зам, хий дамжуулах хоолойн аль нь ч тухайн бүсэд бөхөн тархах талбайг хязгаарлах болон мэнд үлдэхэд айхтар аюул болохооргүй байна.

Залуу бодгалиуд бүхий бие гүйцсэн бөхөнгийн жижиг сүргүүд энэ бүсэд байгаа нь өнөөгийн өөрчлөгдөн буй нөхцөлд хүний хүчтэй нөлөө эдгээр амьтдад болон тэдний амьдрах орчинд нөлөөлсөөр байгаа хэдий ч бөхөн мэнд үлдэж байгааг гэрчилж байна. Томоохон суурингаас алслагдамал энэ нутагт хулгайн ан байдаг бололтой. Асуулгаас үзэхэд орон нутгийн хулгайн анчид Балхаш нуураас зүүн хойш Кентобе хагас арал руу очдог байна. Бөхөнгүүд энд ус уухаар ирж удаан хугацаагаар байршдаг гэнэ. Хулгайн анчид хагас арлын нарийхан хэсэгт байрлах амьтдын мөр жимийн ойролцоо тусгайлж бэлдсэн нуувчуудыг ашигладаг байна. Зүүн Хойд Прибалхашд бөхөн тэмдэглэсэн цэгүүд нь Казахстан дахь энэ зүйлийн тархацын хамгийн зүүн талын нутгууд болж байна. Энэ нутаг нь Бетпакдалийн популяцийн өнөөгийн тархалтын үндсэн нутгуудаас зүүн тийш 1000 км зайд байдаг юм. Энд тусгай хамгаалалттай нутаг байхгүй. Хүрэхэд хол, хүн амын суурьшил бага, харьцангуй хөндөгдөөгүй зэрэг нь бөхөнд нөлөөлдөг хүний сөрөг нөлөөг барьж байгаа гол хүчин зүйлүүд болж байна. Тухайн газарзүйн районд зүйлийн төлөв байдлын байнгын судалгааг явуулах шаардлагатай.



Зүүн Хойд Прибалхашд бөхөн байрших амьдрах орчин

“ВОЗРОЖДЕНИЕ” ХОЙГ ДАХЬ БӨХӨНГИЙН ПОПУЛЯЦИЙН СУДАЛГАА

Нуриджанов Д.А., Нуриджанов А.С.

Узбекистаны байгаль орчны хорооны улсын биохианалт, nuridjanov@mail.ru

WCN болон СИС-ээс санхүүжсэн Бөхөн хамгаалах эвслийн(SCA) жижиг төслүүдийн хөтөлбөрийн

санхүүгийн дэмжлэгтэйгээр 2010 оны хавар “Возрождение” арал дээр бөхөнгийн популяцийг судлах

экспедицийг зохион байгуулав. Возрождение арал нь Каракалпакстаны Муйнакск районд байх бөгөөд хуучин Возрождение, Лазарев, Комсомольский, Константины, Беллинсгаузены арлууд болон Арал тэнгисийн хуучин ёроолыг өөртөө багтаадаг. Үндсэн арлууд өөр хоорондоо их төстэй, загаар хүрээлэгдсэн шарилжит хээр, элсэрхэг газраар тойрог хэлбэрийн сухайнууд ургадаг. Ургамлуудаас янз бүрийн бударгана, хар заг, цагаан марь онцлог. Арал тэнгисийн хуучин ёроол бол ургамлаар ядмаг элсэрхэг, тойром бүхий нутаг юм. Судалгааг үндсэндээ “Возрождение” хуучин арал дээр явуулсан. Бид арлыг бүхэлд нь тойрон явсан юм. Энд тэндгүй бөхөнгийн ул мөр олон тоогоор тааралдаж байв. Энд шүүлтүүрээр бий болсон хэд хэдэн давсархаг задгай уснууд бий. Усны эргэн тойронд үнэг, чоно зэрэг махчдын мөр их байв. Шинжээчдийн үнэлгээгээр 5-6 бодгаль чонотой гэнэ. Хуучин нислэгийн зурвасын районд өглөөний 7.45 –ийн үед бөхөнгийн ооно хөөж буй том чоныг бид харсан. Хожуухан 5 бодгаль (3 ооно, 2 шаргачин) бүхий бөхөнгийн сүрэг энэхүү нислэгийн зурвас дээр бэлчээрлэж байв. Шаргачингууд бэлчих үед оонууд хамгаалдаг. Өмнө нь хагас арал дээрх бөхөнгүүд үргэмтгий бус байсан, харин чичиргээний хайгуулын ажил эхэлсэн болон байнгын тайван бус байдлын улмаас бөхөнгүүд их болгоомжтой үргэмтгий болсон (дугаар №9 харна уу) байв. Түүнчлэн ганцаар давхиж буй ооно Лазаревийн аралд тэмдэглэгдсэн ба өмнө нь (2009 оны 11-р сард) энд 18 бодгаль бүхий бөхөнгийн сүрэг тэмдэглэгдэж байсан.

Бидний ажиглалтаар хагас арал дээр 100-аас багагүй бөхөн байрших бөгөөд арлын хойд хэсэг бараг судлагдаагүй үлдсэн тул түүнээс ч илүү бөхөн байж болох юм. Арлын баруун хэсэгт Арал тэнгисийн хуучин ёроол дээр байгалийн хий



зургийг Д.Нурдиханова

Ер бусын геологийн тогтоцууд хагас арлыг чимдэг.

олборлох өрөм байдаг. Мөн чичиргээний хайгуулын ажил одоо явагдаж бөхөнд сөргөөр нөлөөлж буй Возрождение хагас арлын зүүн хэсэгт хийн өрөмдлөгийн барилга баригдахаар төлөвлөгдсөн байна. Байнгын тайван бус байдлын улмаас бөхөнгүүд арлын хойд хэсэгт голчлон байршиж, хааяа Возрождение үндсэн арал дээрх задгай усанд ордог. Возрождение хагас арлыг хүртэл Арал тэнгисийн хуучин ёроолоор замтай бөгөөд үүн дээр сансрын холбоогоор хангагдсан “Арал тэнгис”-д хамаарах хамгаалалттай хоёр шалган нэвтрүүлэх цэг байдаг. Хамгаалагчдын мэдээлсэнээр Возрождение хагас арлын орчим ганц нэгээр эсвэл цөөн бодгальтай сүргээр бөхөнгүүд байнга харагддаг. Түүнчлэн чоно ч байнга тэмдэглэгддэг гэнэ.

Узбекистаны нутаг дэвсгэр дээр байнга байршдаг ганцхан популяцийг хамгаалахын тулд энд олон улсын хамгаалалттай нутгийг байгуулах шаардлагатай.



зургийг Д.Нурдиханова

Возрождение хагас арал дээрх нуурыг амьтад усны эх үүсвэрээ болгон ашигладаг

БӨХӨН ХАМГААЛАЛ - НИЙТИЙН ҮЙЛ ХЭРЭГ

Хлуднев А.В.

“Степной” байгалийн нөөц газар, ОХУ, angelok-19@yandex.ru

Халимагийн Бүгд Найрамдах улсын тэргүүн 2010 оныг бөхөнгийн жил болгон зарласан нь ОХУ-ын 2009 оны 6-р сард нэгдсэн “Бөхөн хамгаалах тунхаглал”-ыг биелүүлэхэд ач холбогдолтой чухал алхамуудын нэг боллоо. Засгийн газраас баталсан төлөвлөгөөний дагуу бөхөнгийн өнөөгийн төлөв байдлын талаар иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх үүднээс олон янзын арга хэмжээ авч, уралдаан, дугуй ширээний ярилцлагыг зохион байгуулж, хулгайн анчдаас бөхөнг хамгаалж, популяцийн хамгаалалыг сайжруулахад чиглэсэн хөрөнгийг хайсан. Эдгээр арга хэмжээнүүдийн талаар тус улсын сонингуудад байнга мэдээлэгдэж байв. 2009 оны сүүлчээс 2010 оны эхэн хүртэлх хугацаа

бөхөн болон түүнийг хамгаалдаг хүмүүсийн хувьд маш хүнд үе байсныг тэмдэглэх хэрэгтэй. Мөсөн бүрхэвчтэй зузаан цас (зуд хэмээн нэрлэдэг) хамгаалал бараг байдаггүй районууд руу бөхөн нүүдэллэх шалтгаан болж, цас багатай нутгуудад бөхөн тачирхан өвсөөр идэшлэж байв. Яг энд л хулгайн анчид бөхөнг отож байв. Гэхдээ тэдний хулгайн ан бүр шийтгэлгүй үлдсэн гэж үзэж болохгүй. Халимагийн бүгд найрамдах улсыг хамаарах Холбооны аюулгүй байдлын ажилчдын оролцоотойгоор 3-р сарын 11 нд Халимагийн Черноземель районд 19 бөхөн (340 кг мах) агнасан цагдаагийн ахмадыг саатуулсан. Ширүүн өвлийн дараа мэнд үлдсэн шаргачингууд 5-р сарын эхээр төллөдөг үеийн өмнөхөн энэ явдал болжээ.

Хуулийн сахилт, амьтны аймгийн хамгааллыг хангуулах гэж улсаас тусгайлан бэлтгэсэн цагдаа хүнийн энэхүү үйлдлийг хэрхэн тайлбарлах вэ? Хээлтэй шаргачингуудыг халуун зэвсгээр агнаж байгаа нь ямар ч хүн чанаргүй болсныг илтгэнэ. Халимагийн шүүхийн байгууллага эдгээр “хүн адгууснуудад” зохих шийтгэлийг өгөх болно гэж найдаж байна. Амьтны аймгийг хамгаалах бүрэн эрхийг 2008 оны 1-р сард Оросын Холбооны субъектэд шилжүүлсэн боловч эдийн засгийн хямралтай нөхцөлд холбооны төвөөс ирдэг санхүүжилт бага болсон. Энэ нь Халимагт олон жил ажиллаж, 30 гаруй хүний бүрэлдэхүүнтэй бөхөн хамгаалах отрядыг задрахад хүргэсэн юм. Одоо Халимагийн нутаг дэвсгэр дээрх хээрийн туруутны (ер нь бүх биологийн олон янз байдлын) хамгааллыг байгалийн нөөц, хүрээлэн буй орчны хамгаалал болон энергийн хөгжлийн яамны байцаагчид зургаан хүний бүрэлдэхүүнтэй, “Нива” загварын 2 автомашин, нэг “Уаз” машинтай гүйцэтгэж байгаа. Энэ нь хангалтгүй бөгөөд байцаагч нарт ийм нөхцөлд ажиллахад маш хүндрэлтэй. Маш сайн тоноглогдсон хулгайн анчдын араас хөөцөлдөх ямарч боломжгүй. Тэдэнд бөхөн тархах онцлог, хээр талаа маш сайн мэддэг нутгийн иргэд, ялангуяа малчдын бодитой тусламж хэрэгтэй. Зүйлийн хамгааллыг нэн тэргүүнд хариуцдаг хөрш зэргэлдээ район болон тусгай хамгаалалттай нутгуудтай харилцаа шаардагдана. “Степной” нөөц газар байгуулагдсан 2000 оноос эхлэн захиргаа хулгайн анг зогсоох, бөхөн хэвийн үржих нөхцлийг хангах арга хэмжээг авч байна. Байцаагчид нь Астранханск мужийн захиргаанаас тэдэнд хүлээлгэсэн нутаг дэвсгэртөдөр тутмын хамгааллыг гүйцэтгэж байна. Саяхан нөөц газрын нутаг дэвсгэр дээр хоёр хулгайн анчинг барьж нэгийг нь (Прикаспийский тосгоны иргэн) чанга дэглэмтэй хорих ангид 3.5 жил хорих ял оноосон, нөгөөх нь (Яшкульск районы иргэн) шүүхийн шийдвэрээ хүлээж байна. Гэхдээ хямралын нөхцөлд хомс санхүүжилтээр бөхөнгийн найдвартай хамгааллыг хангана гэдэг бараг боломжгүйг шударгаар хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Нөхцөл байдлаа тооцон бид өөрсдийнхөө үйл ажиллагааг хангахад зориулж нэмэлт санхүүжилт хайхаар олон улсын байгаль хамгаалах сангуудтай идэвхтэй хамтын ажиллагаагаа



зургийг А.Хулдеев

Агнасан бөхөнтэйгээ саатуулагдсан хулгайн анчин

үргэлжлүүлж байна. Жишээлэхэд 2009 оны 8-р сард хамгаалалтын захиргаа Бөхөн хамгаалах эвслийн төсөлд шалгарсан. Энэ хөрөнгөөр бид нөөц газрын болон зэргэлдээ нутгуудад бөхөн хамгаалах чиглэлээр нийтдээ 14 мянга орчим км –ийн 40 гаран эргүүл хяналтын ажлыг гүйцэтгэсэн. Төслийн ачаар бид бөхөнгийн ороо нийллэг болон төллөлт явагддаг газарт илүү анхаарч бөхөнгийн хамгааллыг хангах боломжтой болсон. Янз бүрийн хугацаанд байцаагчид нөөц газрын нутагт 300–аас 10000 хүртэл тооны бодгаль бөхөнг ажиглаж байсан. 2010 онд IFAW шуурхай тусламжын хэлбэрээр бидний ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүдэд хоёр шинэ аккумулятор болон дугуй авахад мөнгө өгсөн төдийгүй шинэ машин авахад санхүүжүүлсэн. WWF байгууллагаас шатахуун авахад хөрөнгө гаргасан. WCN –ийн зүтгэлээр бид АНУ-ын хувь иргэдээс авсан хандивын мөнгийг шатахуун авахдаа зарцуулсан. Боломжийг ашиглан “Степной” нөөц газрын захиргаа Баруун Хойд Прикаспийн бөхөнгийн өвөрмөц популяцийг хамгаалах бидний үйлсэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн дээрх байгууллагуудад талархалаа илэрхийлж байна.

Эцэст нь хэрэв бөхөнгийн жил Халимагт төдийгүй бүхэлд нь Баруун хойд Прикаспийд зарласан бол түүний уриан дор тухайн бүсийн Оросын холбооны субъектуудын бүх хамгаалах бүтцүүд нэгдэж тал нутгийн “эрмэл үлдэгдэл” хамгаалах, хадгалж үлдэхэд маш чухал арга хэмжээ болох байсныг тэмдэглэхийг хүсч байна. Бидэнд бөхөн хамгаалах чиглэлээр хүчээ нэгтгэх туршлага бий. 2006-2007 онуудад Халимагийн бүгд найрамдах улсын хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн хорооны удирдлага, “Степной” нөөц газрын захиргаанаас гарын үсэг зурсан бөхөн хамгаалах зөвшилцөл хэрэгжсэн ч харамсалтай нь (нөөц газрын буруугаас биш) сунгагдаагүй. Иймэрхүү шинэ зөвшилцлийн хүрээнд бидний хамтын ажиллагаа үргэлжлэвэл 2010 онд Халимагт төдийгүй Астраханск мужид тэмдэглэсэн арга хэмжээнүүдийг амжилттай явуулахад сайн хувь нэмэр болох байсан. Энэ нийтлэл зөвшилцлийн шинэ бичгийг бэлтгэх ярианы эхлэл болно гэдэгт найдаж байна.



зургийг А.Хулдеев

Өлдөж үхсэн бөхөнгийн шаргачин

ЭМНЭЛЭГТ БӨХӨНГИЙН ЭВРИЙГ ОРЛУУЛЖ ГЭРИЙН ОДОС ҮХРИЙН ЭВРИЙГ АШИГЛАХ НЬ

Гуйхон Цзян

Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг, Хятад gzhang@wcs.org

Бөхөнгийн эврийн тухай бичиглэлүүдийг 2000 жилийн тэртээх “Shengnong Bensaо” судар бичгүүдээс (эмийн бодисын тухай газар эзэмшигчийн бурханы судрууд) олж болно. Хятадын уламжлалт анагаах ухаанд бөхөнгийн эврийн шинж чанарыг “давстай” болон “хүйтэн” гэж тодорхойлжээ. Үүнийг голчлон даралтын өөрчлөлт, таталт, ухаан алдалт, ком, спазм үүсгэдэг өндөр температурыг

эмчлэхэд ашигладаг. “Bensaо Gangmu” (Эмийн бодисуудын тойм) бүтээлд одос үхрийн эврийг мөн “давстай” болон “хүйтэн” гэж тодорхойлж өндөр даралтыг бууруулах, хортой бодисыг гадагшлуулах, цусны даралтыг бууруулахад хэрэглэдэг байна. 1998 онд Хуагийн хийсэн судалгаагаар давхраат хроматографийн аргыг ашиглан бөхөн болон гэрийн буйволын эврүүд

аминхүчлийн агуулгын ижилхэн түвшинтэй боловч зарим бичил элементүүдийн янз бүрийн концентрацитай болохыг илрүүлсэн. Клиник судалгаагаар одосын эвэр цусны даралтыг бууруулж чадахыг харуулсан. Жишээлэхэд, эмийн гишүүт нэмж гэрийн буйволын эврийн нунтагаас бэлтгэсэн Hungjiao Tang (эмийн шөл) нь 121 тохиолдолд 90 %-ийн үр дүнтэйгээр хурц церебраль инфарктыг эмчлэхэд ашигласан байна.

SCA-ийн жижиг төслүүдийн хөтөлбөрийн грантыг 2009 оны 1-р сард бид авсан (SN №10 харна уу) бөгөөд түүнийг WCS-ийн Хятадын хөтөлбөрөөр дамжуулан төслийг хэрэгжүүлэхэд ашигласан. Бид бөхөн хамгаалах баг хэлбэрээр дунд сургуулийн орон нутгийн сурагчдын дунд 3 бүлэг бий болгосон. Багийнхан мэдээллийн боловсруулалт, тэдгээрийг олон нийтэд түгээх үүрэгтэй. Одоогоор эдгээр багийнхан бөхөнгийн эврээс гаргасан эмнүүдийн оронд одосын эврээс хийсэн эмнүүдийг хэрэглэхийг нутгийн иргэдэд ухуулах байдлаар гурван нөхөрлөлтэй амжилттай ажиллаж байна.

“Бөхөн мөнхөд” нэртэй нэг багийнхан эмийн бэлдмэлийн хэрэглэгчидтэй төвлөрч ажиллав. 2010 оны 2-р сараас 3-р саруудад хүүхдүүд өөрсдийн бүтээсэн плакат, материалуудыг ашиглан Хайцзю районы Феникс гудамжинд арга хэмжээ явуулав. Тэд энэ бүсийн хятадын уламжлалт анагаах ухааны аптекуудын ажилтнуудыг итгүүлж тэдний аптекуудад өөрсдийнхөө плакатуудыг өлгүүлж чадсан байна. Энэ аптект эм авахаар цугласан худалдан авагчид бөхөн хамгаалах талаар хуудсууд авцаасан. Багийнхан бөхөнгийн эврийн оронд одосын эврийг ашиглах тухай олон нийттэй нээлттэй яриаг өрнүүлсэн.



зургаа WCS

Гуаньжоугийн автобусанд наасан бөхөн хамгаалах тухай плакатууд

Бусад хоёр багийнхан асуудлын олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллав. Багийнхан бөхөнгийн хамгаалалд зориулсан өгүүлэл, жүжиг, шүлэг зохиож дараа нь түүнийгээ нутгийн иргэдэд жүжигчлэн үзүүлсэн. Тэд хүмүүсээс бөхөнгийн эврээс гаргадаг эмнүүдийн оронд орлуулагч болох гэрийн одос үхрийн эврээс хийсэн бүтээгдэхүүнийг ашиглахыг хүсэж байв. Тэдний үзүүлбэр болон бусад ажлуудын дунд хүмүүс бөхөн хамгаалахын чухлыг ойлгож, бөхөнгийн эврийн оронд одосын эврээс гаргасан бүтээгдэхүүнийг ашиглах хүсэлтэй болж байв. WCS-ийн Хятадын хөтөлбөрийнхөн 6 сарын турш Гуаньжоу хүрдэг №6 автобусанд бөхөнд зориулсан 10 плакатыг байршуулсан юм. Автобус Хятадын уламжлалт анагаахын бүтээгдэхүүн зардаг орон нутгийн захын ойролцоох 3 буудлыг дайрч өнгөрдөг юм. Энэ хугацаанд 150 мянгаас дээш хүн байгаль хамгааллын талын мэдээлэл авсан байна. “Бөхөнгөө хамгааль” нэртэй өөр нэг баг Гуаньжоугийн Тианхэ районы Хуйжинг хотод бөхөн хамгаалахад илүү олон хүмүүсийг татахын тулд гар зургийн уралдаан зохиоход төлөвлөж байна.



зургаа WCS

“Бөхөн мөнхөд” багийнхан өөрсдийнхөө үзүүлэнг уламжлат эм зардаг эмийн сангуудад тараан байршууллаа

ОХУ-Д МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ КОМПАНИТ АЖЛЫН ҮР ДУНГУУДИЙГ ҮНЭЛЭХ НЬ

Хау К¹., Обгенова О²., Милнер-Гулланд Э.Дж¹.

Лондонгийн эзэн хааны коллеж, c.howe.01@cantab.net²Халимагийн бүгд найрамдах улсын экологийн төслүүдийн төв

Байгаль хамгаалах салбарт өргөн ашиглаж буй албан ба албан бус боловсролоор тухайлбал мэдээллийн компани ажлууд байгалийн тухай мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үр дүнтэй хэрэгсэл бөгөөд байгаль хамгаалалд эерэг хандлага бий болгодог болохыг харуулсан. Их Британийн засгийн газрын Дарвины санаачлага сангаас 2006-2008 онуудад байгаль хамгаалах үйл ажиллагаануудын бөхөнгийн тухай мэдлэг, хандлагыг тодруулах зорилгоор 2003-2007 онд ОХУ-д судалгаа хийхээр санхүүжүүлсэн. Энэ ажлыг Лондонгийн эзэн хааны коллеж, Халимагийн экологийн төслүүдийн төв хамтран гүйцэтгэсэн. Бөхөнгийн тухай хүмүүсийн мэдлэг, сүүлийн хэдэн жилд авсан мэдээллээ санаж сэргээж чадаж буйг мэдэхийн тулд, 8 тосгоны 250 гаруй хүмүүсээс асуулга авсан. Тосгонууд

байгаль хамгааллын талаар хийгдсэн үйл ажиллагаараа ялгаатай байсан. Халимагийн 4 тосгонд (Утта, Эрдневский, Молодежный, Адык) компани ажлуудыг бүсийн болон орон нутгийн сонин, телевизээр дамжуулан явуулав. Халимагийн хоёр тосгонд (Хулхутта, Таван-Гашун) бөхөн хамгаалах ухуулгын ажлуудыг идэвхтэй хийв. Түүнчлэн DEFRA-аас санхүүжүүлсэн байгаль хамгаалах жижиг төслүүдийн схемээр (SEPS) дамжуулан саалийн үнээ өгөх төсөл хэрэгжсэн. Астраханьск мужийн Лиманск районы хоёр тосгонд харин хүмүүсийг татах талаар ямар ч ажил хийгдээгүй. Ийм арга хэмжээнүүд зөвхөн “Степной” нөөц газрын орчимд л хийгдсэн байна. Ярилцлага өгөгчидөд тэд хэдэн удаа бөхөн харсан, бөхөнгийн тоо толгойн өөрчлөлтийн тухай тэд мэддэг эсэх, бөхөн хамгааллын орон нутгийн төслүүдийн тухай мэддэг эсэх, бөхөн хамгаалахад ямар нэгэн сайн дурын хувь

нэмэр оруулж чадах талаар асуултууд тавьсан. Тэднээс мөн бөхөнгийн талаар мэдээллийн материалууд авч байсан тухайгаа санаж буй эсэхийг асууцгаасан. Санаж байвал, хэзээ мэдээллийг авсан ямар хэлбэрээр (жишээлэхэд сониноос эсвэл телевизээр), юун тухай байсан (жишээлэхэд экологийн тухай, эсвэл байгаль хамгаалал) болон үүнээс шууд үр дүн гарсан уу (материал хүлээн авсаны дараа ярилцлага өгөгчийн ойлголт өөрчлөгдсөн үү) гэх мэтийг тодруулсан.

Бөхөн болон түүний хамгаалалд хүмүүсийн хандлага

Бүхэлдээ бөхөн болон түүний хамгаалалд эерэг хандлагатай байгааг судалгаа харуулсан. Ярилцлага өгөгчдийн 94% нь хойч ирээдүйдээ зориулж бөхөнгөө хамгаалах нь шаардлагатай гэсэн, 84% нь ОХУ-д бөхөн устаж алга болохын эсрэг байгаагаа хэлсэн.

Мэдээллийн материалуудыг хэн авдаг вэ?

Асуусан хүмүүсийн 76 % нь янз бүрийн хэлбэрийн асуулгын материалуудыг авч байсан тухайгаа санаж байхад саалийн үнээ авах SEPS-ийн төсөлд хамрагдсан тэдгээр хүмүүс материал авсан тухайгаа санасан. Эндээс харахад мэдээллийн кампанит ажлууд зорилгоо биелүүлсэнийг харуулж байна. Магадгүй байгальд маш олон бөхөн харсан эсвэл бөхөнгийн хамгааллын тухай мэдэж буй хүмүүс энэ тухайгаа мартажгүй байх. Бөхөн хамгааллын үйл ажиллагааны тухай анхдагч мэдээ, ойлголт, мөн хүмүүс бөхөнгийн тухай уншиж, үзэж, эсвэл кампанит ажилд оролцсон гэсэн итгэлийг хүчтэй болгож байна гэж эндээс ойлгогдож байна.

Мэдээлэл авах ямар эх үүсвэрүүд байна?

Мэдээллийн кампанит ажилд оролцоогүй (Астраханийн суурингуудад) хүмүүс 2006 оныг хүртэл мэдээллийг зөвхөн телевизээр авч байсан. Ихэнх тохиолдолд мэдээлэл зөвхөн бөхөнгийн амьдралын хэв маяг, экологийн талаар байж харин түүний өнөөгийн хүнд байдал, хамгааллын талаар бус байв. Эсрэгээр, кампанит ажилд оролцсон хүмүүс хоёр эх үүсвэрээс (сонин, телевиз) авсан мэдээллийнхээ тухай болон тусгайлсан сэдвүүд болох экологи, хамгаалал, хулгайн ангийн талаар санаж байна. Эмэгтэйчүүд байгаль хамгааллын талаар эрэгтэйчүүдээсээ бага унших хандлагатай болохыг үр дүнгүүд харуулж байна ($\chi^2=8,986, p=0.029, df=3$).

Мэдээлэл ямар нөлөөтэй байв?

Мэдээллийн материалууд шууд нөлөөлсөн үү үгүй юу (мэдээлэл авах үед бөхөнтэй холбоотой асуудлуудыг ойлгоход өөрчлөлт гарсан уу) гэдгээс хамааралгүйгээр хүмүүсийн хүлээн авалт хүний хүйс болон мэдээллийн эх үүсвэртэй холбоотой байсан. Телевиз бол унших материалаас илүү үр дүнтэй хэрэгсэл байсан, харин эрэгтэйчүүдэд телевизийн мэдээлэл

ХАЙРАА ШИНГЭЭСЭН БҮХЭН ҮР ШИМЭЭ ӨГДӨГ

Нүрүмбетова А.Б.

Нутгийн иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх, орлогын өөр эх үүсвэрүүдийг бий болгох зорилгоор “Онрмент” урчуудын нийгэмлэг бөхөн хамгаалах эвсэлтэй (SCA) хамтран үндэсний гар оёдлын төслийг эхлүүлсэн билээ. Төсөл 2008 онд WCN-ийн дэмжлэгтэйгээр (SN №7.9 харна уу) эхэлж, 2009 онд The Wild Foundation сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр үргэлжилсэн. Сургалтанд хулгайн ан их гардаг хоёр тосгоноос (Жаслык, Каракалпакия) ажилгүй



зургийг К.Хай

Судалгааны багийнхан Яшкульскийн сургуулийн багш сурагчдын хамт

эмэгтэйчүүдээсээ илүү нөлөөлж байв. Мэдээллийг хүлээж авсан хүмүүс ямар нэгэн мэдээллийг санаандаа сэргээж чадахгүй байгаа хүмүүстэй харьцуулбал сүүлийн 3 жилийн хугацаанд бөхөнд эерэгээр хандах болсон байна.

Дүгнэлтүүд

Баруун Хойд Прикаспийн хүн ам бөхөн болон түүний хамгаалалд нийтдээ маш эерэгээр хандаж байгааг судалгааны дүнгүүд харуулж байна. Тэдний ихэнх нь Дарвины санаачилга болон бусад төслүүдийн хүрээнд 2005 оноос энэ бүсэд хийгдсэн олон нийтийн мэдээллийг нэмэгдүүлэх чиглэлийн хөтөлбөрүүдэд хамрагдсан. Энэ бүсэд сонин, телевиз хүн амын ихэнх хэсэгт хүртээмжтэй бөгөөд тэд байгаль хамгаалах чиглэлийн материалуудыг хэвлэх сонирхолтой байв. Мэдээллийн кампанит ажилд янз бүрийн сэдвээр хэвлэлийн төдийгүй телевизүүдийг өргөнөөр ашигла байв. Үр дүнтэй мэдээллийн кампанит ажлыг явуулахад телевиз, хэвлэл зэрэг бүх хэрэгслүүдийг ашиглах нь чухал болохыг судалгаа харууллаа. Бөхөнтэй холбоотой асуудалд хамаатай байдаг, байгаль хамгааллын төсөлд хамрагдаж байсан хүмүүс маш их үнэмшилтэйгээр энэ асуудлаарх хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэвтрүүлгийн тухай санах, анхаарлаа хандуулдаг болохыг судалгаа мөн харуулсан. Энэ нь хүмүүс бөхөнд хандах хандлагаа эерэг тал руу өөрчлөхөд туслаж байна. Иймд, энэ судалгаагаар ХМХ-г ашиглах нь байгаль хамгааллын, ялангуяа бусад байгаль хамгааллын арга хэмжээнүүдтэй хамтдаа үр дүнтэй бүрэлдэхүүн нь болохыг харуулав.

эмэгтэйчүүдийг урьсан. Энэ үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийг татан оруулсанаар тэдгээрээр болон тэдний гэр бүлээр дамжуулан бөхөн хамгаалахад нэгтгэж, бөхөнгийн хямд мах худалдан авахаас тэднийг татгалзалзуулж чадна гэдэгт бид итгэж байна. 2009 оны хавар, зун Каракалпакскийн үндэсний гар оёдлын урлаг, нууцад хүүхнүүдийг сургасан хэд хэдэн сургалт семинарыг зохион байгуулав. Бидний зорилго бол зөвхөн тэднийг гар урлалд сургах төдийгүй, цаашдаа

бусад эмэгтэйчүүдийг гар урлалын эв дүйд сургаж ажиллах чадвартай удирдагчдыг илрүүлэх, хүмүүжүүлэх явдал байсан. Семинарын үеэр хүүхнүүд сэтгэлзүйн сургалтуудад хамрагдаж, Савицкогийн нэрэмжит урлагийн болон ёс заншлын музейг үзэж сонирхон орон нутгийн гар урлалын бүтээлүүдийн уламжлалт загваруудтай танилцав. Энэ бүхэн тэдний цаашдын хөгжилд түлхэц болов. Орон нутгийн телевизээр гарч, сонингуудад ярилцлага өгсөн нь тэдний өөрсдийг үнэлэх үнэлэмжийг их болгож өгчээ. Сургалтын дараа бүх эмэгтэйчүүд Каракалпакстаны эмэгтэйчүүдийн хороо болон “Онермент” урчуудын нийгэмлэгээс гэрчилгээ авцгаав. Сургалтын төгсгөлд бид Жаслык суурингын оршин суугчидтай амжилттай эхэлсэн хамтын ажиллагаагаа үргэлжлүүлсэн. Бие даасан гар оёдолд шаардлагатай бүх материалуудыг бэлтгэн тэдэнд өгөв. 6 сарын туршид бид Кунград районы хүүхнүүдтэй харилцаатай байлаа. Тэдний дунд Майна Бийсенбаева удирдагчаар ялгарч тэрээр Нукус руу бие даан ирж, захиалагаа өгсөн. ӨКаракалпакстаны гар урлалын дадлыг эзэмшсэн 15 хүүхнүүдээс бүрдсэн бүлгийг байгуулж чадсан төдийгүй, өөрсдийнхөө анхны мөнгийг олж эхэлсэн байна.

Манай бүсгүйчүүд чанартай сайн хийсэн бүтээлүүдээрээ Майна Нукус хотноо 2010 оны 3-р сарын 11-нд болсон Узбекистан улсын ерөнхийлөгчийн нэрэмжит “ТАШАББУС -2010” уралдаанд оролцов. Урьдчилсан бэлтгэл, хичээл зүтгэл нь энэ бүсгүйд уралдааны шагналтан болж, нэр хүндтэй диплом гардан авах боломжыг олголоо. 4-р сарын сүүлчээр Жаслыкын урчуудын бүлэг бөхөнгийн өдрийн хүрээнд өөрсдийнхөө бүтээлийн үзэсгэлэнг зохион байгуулав. “Онерментийн” гишүүд ч баярт оролцсон. Тэд Майнагийн гэр бүл, бүлгийн гишүүдтэй танилцаж,

ТӨСЛҮҮДИЙН ТОЙМ



ОХУ-ЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМ/НУБХХ/ГЭФ-ИЙН ХЭЭРИЙН ТӨСӨЛ БӨХӨН ХАМГААЛАЛД ТУСЛАНА.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМ/НУБХХ /ГЭФ-ийн “Оросын хээрийн биом дахь ТХГН-уудын удирдлагын механизм болон системийг сайжруулах нь” нэртэй таван жилийн төсөл 2010 оны 5-р сард эхэлсэн (Степной бюллетень №25, 2009 болон №28, 2010-<http://www.sibecocenter.ru/sb.htm>). ГЭФ болон НУБХХ энэ төсөлд 5.3 сая доллар гаргажээ. Оросын хувьд энэ бол хээрийг хадгалж үлдэхэд тусгайлан чиглэсэн ГЭФ-ийн анхны томоохон төсөл юм. Одоо байгаа ТХГН-уудын сүлжээг хэвийн үйл ажиллагаатай болгох, газар нутгийн хамгаалал бүхий хээрийн экосистемийн талбайг нэмэгдүүлэх замаар Оросын хээрийг хадгалж үлдэхэд ТХГН-уудын үүргийг нэмэгдүүлэхэд төсөл чиглэж байгаа. Төсөл 3 үндсэн бүрэлдэхүүнтэй: 1) хээрийн ТХГН-уудын системийн бүтэн байдлыг нэмэгдүүлэх, өргөтгөх; 2) ТХГН-уудын хээрийн бүсүүдийн шуурхай удирдлагын боломжыг нэмэгдүүлэх; 3) ТХГН-уудын өргөтгөсөн системийн удирдах чадварыг нэмэгдүүлэх. ГЭФ-ийн гол хандлагатай уялдан, үндсэн арга хэмжээнүүдийг завсарын төлөөлөл дөрвөн бүсэд, мөн тэндхийн хээрийн 4 дархан газарт төвлөрүүлэх болно. Эдгээр бүсүүдийн (Читинский, Оренбургский, Курский мужуудаас гадна) нэг бол Халимагийн Бүгд найрамдах улс юм. Энд гол төсөл



зургийг Онермент

Бийсенбаева Майна- Жаслык тосгондахь урчуудын бүлгийн ахлагч

ирээдүйн төлөвлөгөөг нь хэлэлцэн, нэмэлт сургалтууд явуулж хоёрдох бүлгийг бий болгох оролдлого хийлээ. Устюртийн бүсгүйчүүдэд цаашид өөрсдийгөө хөгжүүлэх хүсэл бий болсон нь хамгийн баяртай зүйл байв. Жишээлэхэд казахын гар урлалыг эзэмшсэнээр тэд бүтээгдэхүүнүүдээ амжилттай худалдах боломжтой болно³. Устюртэд гар урлалыг хөгжүүлэх төслөө бид үргэлжлүүлж байгаа. Бидний гол зорилго бол энэ үйл ажиллагааг тогтвортой бие даасан болгох явдал юм. Үүний тулд бид Майнад хувийн үйлдвэрлэгчийн патент бүрдүүлэх, Каракалпакстаны урчуудын нийгэмлэгийн бүрэн эрхт гишүүн болоход нь тусалсан. Мөн оёдлын машин авахад нь тусалсан. Хэрвээ бүсгүйчүүд Каракалпакгийн гар оёдол дээр нэмж, казахын гар оёдлоор оёж эхлэх юм бол Устюртийн суурьшмал газруудад шууд шаардлагатай байгаа жижиг бизнесийн хөгжил хурднаар явах болно гэдгийг бид харж байна.

хэрэгжих ТХГН бол Улсын байгалийн шим мандлын “Черные земли” дархан газар, түүний гол зорилтуудын нэг бол бөхөнгийн популяцийг хамгаалах явдал юм. Төслийн хүрээнд дархан газар өөрийн удирдлага дор холбооны ач холбогдолтой (“Меклетинский” болон “Сарпинский” Байгаль орчны яамны анхны шийдвэрээр аль хэдийн шийдэгдсэн) нийт 300 мянган га талбайтай хоёр нөөц газрыг авах ёстой. Хулгайн ангийн сэдэлтийг багасгах, дархан газартай үүсэх маргааныг бууруулах,



зургийг А.Паженикова

Шренкийн алтан зул цэцгүүд цэцэглэж байна

⁴ редакцийн зүгээс: Устюртийн тэгш өндөрлөгийн узбекийн хэсэгт хүн амын ихэнх хэсгийг 98% -г казахууд бүрдүүлдэг.

хамгааллын дэглэмийг сахиулахын тулд дархан газартай хөрш зэргэлдээ газар эзэмшигчидтэй үр дүнтэй харилцааг бий болгоход төслөөс дархан газарт туслана. Өөрийнхөө үндсэн үйл ажиллагааг сайжруулахад нь бүх талын дэмжлэгийг дархан газар авна: үүнд нэмэлт хангамж тоноглол, хамгааллын сургалт, дархан газрын хүрээнд бөхөнгийн популяци болон цөлөрхөг хээрийн экосистемийн мониторингийн системийг хэвийн болгох зэрэг болно. Сүүлийн жилүүдэд бөхөнгийн хувьд аюултай болоод буй ихээхэн хэмжээнд хээрийн түймрийг зохицуулахад онцгой анхаарах болно. Бөхөнг төслийн түлхүүр таван зүйлүүдийн нэгээр сонгосон. Үүнтэй холбогдож, түүнийг хамгаалах бүсийн үйл ажиллагааны төлөвлөгөө, холбооны стратегийг боловсруулах болно. Энэ чиглэлийн хүрээнд төсөл зүйлийн хамгааллыг сайжруулах нэн тэргүүний практик арга хэмжээнүүд болон тооллогын ажлуудыг сэргээн дэмжих юм (Эхлээд ТХГН-ын хүрээнд). Бөхөнгийн хамгааллыг нэмэгдүүлэх аргуудын нэг бол хулгайн антай тэмцэхэд зориулж байгууллага хоорондын хамтын үйл ажиллагааг уялдуулж зохион байгуулах юм. Бөхөнг хамгаалах асуудалд төслийн хандлагын эх үндэсийг зүйлд учруулж буй аюул болон түүний эсрэг авах арга хэмжээтэй



зургийг И.Смелянский

Синий Сыртын дэгнүүлт хялганат хээр

иж бүрнээр нь авч үзэх зарчмыг баримтлах болно
Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл төслийн техникийн зөвлөх И.Смелянскийд хандана уу steppe.bull@gmail.com

БӨХӨНГ ХАМГААЛАХЫН ТУЛД СУРГУУЛИУДТАЙ АЖИЛЛАХ НЬ

“Тогтвортой хөгжлийн системийн боловсролын арван жил” НҮБ-ийн хөтөлбөрийн хэсэг болох тогтвортой хөгжлийн системийн боловсрол нь боловсролын өнөөгийн системийг өөрчлөх, сайжруулахад чиглэсэн түлхүүр хандлага бөгөөд үүний ачаар сурагчид бүх түвшинд мэдлэг олж авах, Монгол дахь тогтвортой хөгжлийг дэмжихэд зориулсан туршлага олж авах юм. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар - 2004 оноос эхлэн энэ хандлагыг Монголд ашиглаж эхэлсэн анхны байгууллага юм. Манай төрийн бодлогын нэг хэсэг бол байгаль хамгаалал бөгөөд багш нарыг нь сургах замаар сургуулиудад оюуны хөрөнгө оруулалт хийхэд төвлөрөх нь чухал гэж бид үзэж байна. “Баруун Монголын их нууруудын сав газар дахь бөхөнгийн хамгаалал” төслийн хүрээнд бөхөнгийн тархац нутгуудад байрших сургуулиудад энэ хандлагыг ашиглаж байна. Сургалтын жилийн хугацаанд хоёр удаа 2009 оны 11-р сар, болон 2010 оны 5-р сард 5 сургууль дээр хөдөлгөөнт сургалтуудыг явууллаа. Тогтвортой хөгжлийн системийн сургалтуудын онцлог бол сургуулийн захиргаа, удирдлага, багш болгоныг идэвхтэй татан оролцуулах явдал юм. Орон нутгийн түвшинд зохих сургалтын төлөвлөгөөнүүдийг боловсруулах, түүнийг шалгах,

нэвтрүүлэхдээ багаар ажиллах, WWF-тай байнгын харицаатай байхыг оролцогчдоос бид хүсдэг. Сургалтуудын төгсгөлд багш нар бөхөнгийн хамгааллын зорилтуудыг зөвхөн экологийн асуудлуудыг шийдэхэд бус, мөн эдийн засаг, нийгмийн хандлагаа шийдэхэд хамруулж оролцуулсан 18 сургалтын төлөвлөгөөг боловсруулсан.

Түүнээс гадна 2010 оны 4-р сарын сүүлчээр “Тогтвортой хөгжил ба бөхөн хамгаалалын хоорондох холбоо” сэдвээр практик семинарыг зохион байгуулав. Шилдэг багш нар тогтвортой хөгжлийн системийн боловсролын талаарх өөрсдийн дадал, арга барилаа ангид заасан нь оролцогчдод энэ дэлхий нийтийн хандлагыг илүүтэй ойлгох боломж олгосон. Төслийн санаачлагыг аймгуудын боловсролын хэлтэс болон сургуулийн удирдлагууд дэмжсэн. Боловсролын хэлтэс болон түүний арга зүйчдийн үүрэг багш нарын сургалт явагдах үед маш чухал байсан. Төсөл хэрэгжиж буй сургуулиудад бүх багш нар тогтвортой хөгжлийн системийн боловсролын өөрсдийн хандлагаа тодорхойлж, сургуулиуд дээрээ энэ системийн загварыг (жишээ, арга, материалуудаа оруулан) шалгасан. Практик сургалтаар энэ бол сайн үр дүнд хүрэх үр дүнтэй зам болохыг харуулсан. *Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Мэдээлэл харилцааны хөтөлбөрийн менежер Хуланд хандана уу khulan@wwf.mn.*

БҮТЭЭЛЧ ХӨДӨЛМӨР- АМЖИЛТЫН ҮНДЭС



Бөхөнгийн тухай хамгийн бүрэн мэдээлэл агуулсан “Арслан зааны үе тэнгийнхэн бидэнтэй хамт” нэртэй компакт диск бүтээхээр Яшкуль суурингын Төв номын сангийн номын санч Екатерина Очировагийн гүйцэтгэсэн төсөл амжилттай дууслаа.

Халимагийн бүгд найрамдах улсын тэргүүний шагнал улсын уралдааны “Бүтээлч хөдөлмөр-амжилтын үндэс” номинацид боловсролын байгууллагуудын номын сангийн ажилчдын дундаас Екатерина маргаангүй ялагч боллоо. Диск “Бөхөн- байгалийн гайхамшиг” гэсэн хуудсаар нээгдэж, бөхөнгийн амьдралын хэлбэр, тархац, гарал үүслийн тухай мэдээлэл агуулсан номнуудаас иш татан оруулжээ. Дараачийн бүлгүүдэд “Бөхөн хамгаалал бол бидний нийтийн үйл хэрэг”, “Дархан газрууд” гэсэн чухал сэдвүүдийг хөндөж бөхөн хамгааллын асуудлууд, Халимагийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй байгаль хамгааллын байгууллагуудын тухай бүрэн мэдээлэл агуулсан байна. “Уран зохиолын хуудас”, “Халимагийн ардын урлагт Бөхөн” гэсэн бүлгүүдэд бүрэн текст оруулсан зохиолын эх үүсвэрүүдийн ном зүйн бичиглэл хамаарна. “Изографика”, “Фотогалерей” бүлгүүд уншигчдыг бөхөнд зориулсан Халимагийн зураач,

зурагчигуудын бүтээлүүдтэй танилцуулна. “Хялганын өлгийд” гэсэн компьютерийн танилцуулга тусгай бүлгээр оржээ. Энэ мэдээллийн дискний хамгийн чухал бүрэлдэхүүн бол ном, өгүүлэг, сонин, Интернет ишлэл авсан жагсаалт бүхий “Номзүй” юм.

Төсөл нь байнга сайжруулах болон материалуудаа шинэчлэх боломжтойгоороо сонирхол татаж байна. Энэхүү анхны бөгөөд одоохондоо ганц дискийг Яшкульск районы соёлын хөдөөгийн ажилчдын зөвлөлгөөн болон бөхөнгийн жилийн хүрээнд явагдсан арга хэмжээнүүд, хэд хэдэн боловсролын байгууллагууд дээр танилцуулсан байна. Энэ ажил маш их сонирхол татаж, зөвхөн Яшкульск районы боловсролын байгууллагууд төдийгүй, Халимаг улсын хэмжээнд бүх боловсролын байгууллагуудад байх хэрэгтэйг онцолж олон тооны санал хүсэлтүүд иржээ. Халимагийн бүгд найрамдах улсын зэрлэг амьтны төвийнхөн төслийн зохиогч Екатерина Очироваатай хамтран одоогоор тухайн дискийг сайжруулах тал дээр ажиллаж байгаа боловч харамсалтай нь түүнийг бүтээх, шаардлагатай тоо хэмжээгээр хэвлэхэд зориулсан хөрөнгө бидэнд одоохондоо алга байна. Гэвч бид зохих дэмжлэг олж чадна гэдэгтэй итгэж байна. *Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Н.Ю.Арыловад хандана уу arylova@gmail.com*



ШИНЭ БҮТЭЭЛҮҮД

Сингх. Н.Дж., Грачев Ю.А., Бекенов А.Б., Милнер-Гулланд Э.Дж. Сөрөг нөлөөлөл өсөн нэмэгдэж буй нөхцөлд бөхөн үржлийн нутгаа сонгох нь// Biological conservation 143, 2010. – X.1770-1779.

Олонх хуурай газрын хөхтөн амьтад үржлийнхээ нутгуудад бөөгнөрдөг. Ийм бөөгнөрөл бий болоход тэжээл болон усны хүртээмжийн өөрчлөл, махчид болон тайван байдлыг алдагдуулах нөлөөнөөс зугатаах боломж чухал байдаг. Ховордож буй бөхөн бол тийм зүйлүүдийн нэг. Бид сүүлийн 40 жилийн хугацаанд Казахстанд агаарын болон газрын судалгааны үед бөхөнгийн төллөх нутгуудын байршлын тухай орон зай-цаг хугацааны мэдээллүүдийг зүйлийн дэлхэц нутгийн хүрээнд үржлийн нутгуудаа сонгоход нөлөөлөх хүчин зүйлүүд болон эдгээр газруудын улирлын байршил дахь өөрчлөлтийг тогтоохын тулд шинжилж үзсэн. Тохиролдлын газруудаас үржлийн нутгуудыг ялгах хүчин зүйлүүдийг үнэлэх болон төллөхөд тохиромжтой газруудын байршлыг урьдчилан хэлэхийн тулд ашиглалт-хүртээмжийн нэгтгэгдсэн давхацсан загваруудыг боловсруулсан. Бөхөнгүүд хүмүүсийн суурин газраас алс, усны эх үүсвэрээс холгүй байрших олон жилийн ургамалжилтын гарцын өөрчлөлт багатай, ургамлын гарц нь дундаж хэмжээнээс бага нутгуудыг сонгосон байсан. Сүүлийн 10 жилийн туршид бөхөнгийн төллөх газруудын байршилд нэлээд өөрчлөлт ажиглагдсан. Бөхөн хойд зүгт алс шилжин, суурин газруудаас бүр хол алслагдах болсон. Төллөх нутгуудын сонголт нэлээд хэмжээнд хүрээлэн буй орчны хүчин зүйлүүдээр тодорхойлогдогыг үр дүнгүүд харуулж байна. Гэвч тайван байдлыг алдагдуулах хүчин зүйл төллөх газруудын сонголтод хүчтэй нөлөө мөн үзүүлдэг. Сүүлийн 10 жилд түүний нөлөө хүрээлэн буй орчны нөлөөнөөс давж байна. Тайван байдлыг алдагдуулах хүчин зүйлийн нөлөө нэмэгдэх нь хууль бус агнуур болон Зөвлөлт холбоот улс задарсаны дараагаар малын бэлчээр газар ашиглалтын эрч эрчимтэй багассантай холбоотой бөхөнгийн тоо толгой эрс багассантай давхацдаг. Иймэрхүү судалгаанууд дээр үндэслэсэн урьдчилсан мэдээллийн загварууд төллөх үеийн бөхөнгийн шаргачингуудын хамгаалал, үр дүнтэй мониторингоор зүйлийн хамгааллыг сайжруулж болох юм.

Сингх. Н.Дж., Грачев Ю.А., Бекенов А.Б., Милнер-Гулланд Э.Дж. Төв Ази дахь ургамалжилтын эрэлд: Бөхөнгийн нүүдэл // Diversity and Distributions 16, 2010.- X. 663-675.

Тэжээл, ус, махчдаас болон хатуу ширүүн цаг уурын нөхцлөөс хаацайлах нөмөр хайж хуурай газрын амьтад алс хол нүүдэлдэгийг бүгд мэднэ. Энэ үзэгдэл судлагдаж байгаа боловч одоог хүртэл нүүдэлдэг зүйлүүдийн талаарх бидний мэдлэгт том орон зай хоосон хэвээр байна. Төв Ази болон Прикаспийд бөхөн хол зайд нүүдэлдэгийг бид мэднэ. Зөвлөлт холбоот улс бүрэлдэх, задрахтай холбогдож сүүлийн зуун жилд болсон нийгэм-улс төр болон газрын харилцааны өөрчлөлтүүд бөхөнгийн популяци, дэлхэц нутгийн нэлээд өөрчлөлтүүдийг араасаа дагуулсан. Бид бөхөнгийн 4 популяцийг харьцуулж, тэдгээрийн дэлхэц нутаг, нүүдэллэх экологийн шалтгаан, улирлын байршлыг тодорхойлох хүчин зүйлүүд дээр ялгааг тодруулсан. Дэлхэц нутгуудын хоорондох ялгааг судлахдаа 40 жилийн хугацаандах шууд ажиглалтын өгөгдлийг ашиглан хөрсний үржил шимийн улирлын өөрчлөлт, тунадасны хэмжээ, газарзүйн байршлын хувьсууд гэсэн үзүүлэлтүүдэд тулгуурласан. Бүх 4 популяциуд үржил шимийн улирлын өөрчлөлтөөр өргөрөгийн дагуу нүүдэллэдэг нь хур тунадасны хэмжээний өргөн хүрээний өөрчлөлттэй нягт холбоотой. Орон нутгийн газарзүйн болон уур амьсгалын ялгаанууд бүх популяцийн амьдрах орчны улирлын орон зай-цаг хугацааны хувьсалуудыг тодорхойлдог. Завсарын үржил шим болон түүний өөрчлөлтийн багахан жилийн үзүүлэлтүүд улирлын дэлхэц нутгийн доторх байршлын сонголтонд илүү хүчтэй нөлөөлдөг. Казахстаны бөхөнгийн нүүдэл бол үржил шимээр тодорхойлогддог, хэдийгээр саяхан популяцид учирсан сөрөг нөлөө байгаа ч бусад хүчин зүйлүүд нөлөөлөөгүй байсан. Прикаспийн бүсэд бөхөнгийн нүүдэллэх байдал тодорхойгүй байна. Бүх 4 популяци амьдрах орчны алдагдал, хулгайн ан, хүрэлцээгүй хамгаалал, зүйлийн биологийн талаар бидний экологийн мэдлэг дутмагаас улбаатай аюулуудын дор оршиж байна. Бөхөнгийн нүүдлийн шалтгааныг янз бүрийн түвшинд илүү гүн ойлгох нь эдгээр асуудлуудыг шийдэхэд эхний алхам болох ёстой.

ТАЛАРХАЛ

Сүүлийн 6 сарын туршид бидний үйл ажиллагааг дэмжиж байсан Марджори Паркер, Мишель Хакетт, Дарлин Маркович, Кент болон Глори Маршаллов, Стивен болон Карин Чейсон, Монфорт Джойс, Ким болон Кевин Никейннов, Борис Станк нарт бөхөн хамгаалах эвслээс гүн талархаж байна. ОХУ-д болсон хүнд өвөл болон Казахстанд болсон бөхөнгийн их үхлийн дараа бөхөнгийн популяцийг сэргээхэд хувь нэмрээ оруулсан Кеннон Хадсон, Джефф Флокен, Джессика Кулер, Сюзан Вайтинг, Энтони Денсер, Брентон Хэд, Ханно Шифер, Роберто Коломмо, Гирд Момузейт Мэмузевикьют, Барбаре Палмер, Никодемус Коллоредо, Грэму Элиот болон Майкл Монпемму нарт гүн талархалаа илэрхийлэхийг хүсч байна. Бид манай ажилд туслаж байсан WCN болон FFI-ийн ажилчид, сайн дурынханд, түүнчлэн энэ дугаарыг гаргахад дэмжлэг үзүүлсэн WCN болон WWF-Монгол байгууллагуудад талархалаа илэрхийлж байна.

Редакцийн зөвлөл. Их Британи: проф. Э.Дж. Милнер-Гулланд (зөвлөх редактор), Лондонгийн эзэн хааны коллеж (e.j.milner-gulland@imperial.ac.uk); Казахстан: проф.А.Бекенов болон Ю.Грачев, амьтан судлалын хүрээлэн (teriology@mail.ru); Хятад: Г.Цзян, WCS Хятад (gzhang@wcs.org); Монгол: дэд проф. Б.Лхагвасүрэн, Б.Чимэддорж, WWF-Монгол (lkhagvasuren@wwf.mn; chimeddorj@wwf.mn); ОХУ: А.Лушекина, Экологи, эволюцийн судалгааны хүрээлэн (rsmabcom@gmail.com) болон проф. Ю.Арылов, Халимагийн зэрлэг амьтны төв (kalmisaiga@mail.ru); Узбекистан: Е. Быкова (гүйцэтгэх редактор) болон А.Есипов, аАмьтан судлалын хүрээлэн (esipov@xnet.uz). Зургаан хэлний аль дурынх дээр материалаа ирүүлэхийг таниас хүсч байна. Материалаа esipov@xnet.uz хаягаар эсвэл редакторуудын хэн нэгэнд илгээнэ үү. Сэтгүүл жилд хоёр удаа гардаг. Англи болон орос хэлнүүд дээрх зохиогчдод зориулсан журмыг www.saiga-conservation.com хуудсаас эсвэл редакторуудаас хүсэлтээ гарган авч болно. Хэрвээ танд асуулт гарвал танай улсын Saiga News- ийн редактортай эсвэл гүйцэтгэх редактор Елена Быковатай (esipov@xnet.uz) холбогдоно уу.

Энэ дугаар онлайн хэлбэрээр www.saiga-conservation.com, <http://saigak.biodiversity.ru/publications.html> болон <http://www.wildlifewarden.net/wcs/mini/saiga-chinese.pdf> сайтуудаас pdf форматаар эсвэл сэтгүүл хэлбэрээрээ хүсэлтийн дагуу англи, казах, хятад, монгол, орос, узбек хэл дээр редакторуудаас нь авч болно.